

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР



**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

/2017 он эхний хагас жил/

Улаанбаатар хот.

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Стратегийн зорилт 2.4.1-ийн хүрээнд;

- 1.1 Татварын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар
- 1.2 Гадаад хамтын ажиллагаа, давхар татварын гэрээний талаар
- 1.3 Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар.

Хоёр. Стратегийн зорилт 2.4.2-ийн хүрээнд;

- 2.1 Татварын мэдээ, мэдээлэл, статистикийн талаар.
- 2.2 Програм хангамж, компьютер, төхөөрөмжийн засвар үйлчилгээний талаар
- 2.3 Татвар төлөгчийн бүртгэлийн талаар
- 2.4 Татварын тайлан хүлээн авалт, тайлангийн ирцийн талаар
- 2.5 НӨАТ-ын цахим баримт бүрдүүлэлт, урамшууллын талаар
- 2.6 Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний талаар
- 2.7 Татварын өр, тайлант оны ногдлыг барагдуулах ажлын талаар
- 2.8 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар
- 2.9 Эрсдэлийн удирдлагын талаар
- 2.10 Татварын хяналт шалгалтын талаар
- 2.11 Татварын маргаан шийдвэрлэлтийн талаар

Гурав. Стратегийн зорилт 2.4.3-ийн хүрээнд;

- 3.1 Татварын үйлчилгээний талаар.
- 3.2 Татвар төлөгчдийн сургалтын талаар.
- 3.3 Татварын албаны үйл ажиллагаа, татварын хууль, тогтоомжийн сурталчлах талаар.
- 3.4 Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах талаар

Дөрөв. Стратегийн зорилт 2.4.4-ийн хүрээнд;

- 4.1 Удирдлага, зохион байгуулалтын талаар
- 4.2 Дээд газрын тогтоол шийдвэр хэрэгжилтийн талаар
- 4.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний талаар
- 4.4 Хүний нөөцийн талаар.
- 4.5 Шагнал, урамшууллын талаар
- 4.6 Төрийн албаны салбар зөвлөлийн ажлын талаар
- 4.7 Авлига, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- 4.8 Албан хаагчдыг сургалтад хамруулан, мэргэшил, мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар
- 4.9 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар
- 4.10 Нийтийг хамарсан арга хэмжээний талаар
- 4.11 Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаар
- 4.12 Үйлчилгээ аж ахуй, хангалт, засвар тохижилтын талаар

Тав. Стратегийн зорилт 2.4.-ийн хүрээнд;

- 5.1 Дотоод бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар
- 5.2 Харьяа нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар

Зургаа. Цаашид анхаарах зарим асуудал

Долоо. Дүгнэлт

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, “Монгол Улсын Тогтвортой үзэл баримтлал-2030”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд албан татварын чиглэлээр тусгагдсан зорилтууд, Сангийн сайдын 2016 оны 301 дүгээр тушаалаар баталсан “ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” хэрэгжүүлэх зорилгоор ТЕГ-ын даргын 2017 оны А/12 дугаар тушаалаар “ТЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4 жилийн төлөвлөгөө”, 2017 оны А/13 дугаар тушаалаар “Татварын албаны 2017 оны үйл ажиллагааны зорилт”-ыг тус тус батлан 2017 оныг Татварын албаны хэмжээнд “ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН БҮРТГЭЛИЙГ САЙЖРУУЛЖ, ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЖИЛ” болгов.

Дээрх эрх зүйн баримт, бичгүүдийг удирдлага болгон Төсвийн тухай хуулийн дагуу Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2017 оны үр дүнгийн гэрээг байгуулж, Татварын ерөнхий газрын төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 71 ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан болно.

Нэг. Стратегийн зорилт 2.4.1. “Татварын эрх зүйн олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгоход шийдвэр гаргах түвшиний байгууллагад дэмжлэг үзүүлж, хууль хэрэгжүүлэх арга зүйг сайжруулах, холбогдох судалгаа, санал, зөвлөмжийг мэргэшлийн өндөр түвшинд боловсруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх” хүрээнд;

1.1 Татварын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох талаар

ОУВС болон Монгол Улсын Засгийн газрын хэлэлцээрийн хүрээнд татварын орлогыг нэмэгдүүлэх, Монгол Улсын 2017 оны төсөвт тодотгол оруулах болсонтой холбоотойгоор Хувь хүний орлогын албан татвар /ХХОАТ/, Онцгой албан хууль /ОАТ/ болон Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай УИХ-ын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг УИХ-ын Төсвийн байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулав.

Засгийн газраас өргөн барьсан 4 салбарт үйл ажиллагаа эрхэлж буй ААН-ийн төлөх ААНОАТ-ыг 90 хувь хөнгөлөх хуулийн төсөлтэй холбоотойгоор 2015 оны татварын тайлангийн болон Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд үндэслэн 17 багц мэдээлэл боловсруулан УИХ-ын Төсвийн байнгын хороо, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд оролцон тайлбар хийлээ.

Засгийн газраас УИХ-д өргөн барьсан “ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдөр УИХ-ын Төсвийн байнгын хорооны хурлаар, 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганы хуралдаанаар тус тус хэлэлцэн батлуулахад ажлын хэсгийн хүрээнд оролцон, холбогдох судалгаа мэдээллээр хангаж, тайлбар өгч ажилласан. Хууль батлагдсантай холбоотойгоор татвар төлөгчид үзүүлэх татварын хөнгөлөлтийн тооцооллыг УИХ-ын Тамгын газарт цахим шуудангаар хүргүүлсэн болно.

Татварын ерөнхий хууль, ААНОАТ, ХХОАТ-ын тухай, Хөрөнгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн төслүүдийг боловсруулж Сангийн яаманд 2017 оны 3 сарын 27-ны өдөр хүргүүлээ. Хуулийн төслийг боловсруулахдаа Англи, Австрали, Америк, БНСУ гэх мэт 12 улсын туршлагыг судлах, ОУВС-ын Техникийн тусалцааны баг, ЖАЙКА-гийн төслийн зөвлөхүүдээс зөвлөгөө авах, Сангийн яам, ТЕГ-ын зохион байгуулалтын нэгж, татварын албад төслийг хүргүүлж санал авах, удаа дараа уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 333 дугаар тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам”, “Сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Сангийн сайдын 2017 оны 37 дугаар тушаалаар батлуулсан. Уг тушаалыг ХЗДХЯ-ны нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актны 3591 дүгээрт бүртгүүлэв.

Арилжааны банкуудын 2016 оны төгрөгийн зээлийн сар бүрийн хүүгийн хэмжээнд үндэслэн 2017 онд баримтлах татварын алдангийн хэмжээг тооцоолж, алдангийн хэмжээ тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 30 дугаар тогтоолыг батлууллаа.

“Татварын албаны дүрэм”-ийн төсөлд яамдаас ирүүлсэн саналыг тусган боловсруулж, танилцуулгын хамт Сангийн яаманд хүргүүлэв. Мөн бодит үнэ тооцох журмын зассан хувилбарыг Сангийн яаманд 2017 оны 3 сарын 31-ний өдрийн 02/910 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

УИХ-ийн Байнгын хорооны тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сангийн болон бусад сайдын шийдвэрээр 10 ажлын хэсэг, зөвлөлийн бүрэлдэхүүнд орж, хурал, уулзалтад оролцох, холбогдох эрх зүйн актыг судлах, татварын талаарх мэдээ, судалгаагаар хангах, хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх ажлыг хийв. Тухайлбал Казиногийн тухай, Зөрчлийн тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай, Өрсөлдөөний тухай хуулийн төсөл боловсруулах, Инновацийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах, “Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө”-нд тусгагдсан асуудлаар холбогдох санал, дүгнэлт гаргах, “Экспорт гарч буй уул уурхайн бүтээгдэхүүний АМНАТ тооцох зах зээлийн үнийг нийтэд мэдээлэх зэрэг ажлын хэсгүүд, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний зөвлөл, Монгол Улсад төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тогтворжуулах гэрчилгээ олгох асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд орж ажиллав.

Төрийн байгууллага, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулсан тухай бүрт цахим төлбөрийн баримтад үндэслэх, үүнийг хэвшүүлэхийг үүрэгжүүлсэн шийдвэрийг гаргуулах саналыг Сангийн яаманд албан бичгээр хүргүүлээд байна.

ТИНЗ нийгэмлэгээс зохион байгуулсан Татварын зөвлөхүүдийн чуулга уулзалтад татварын бодлогын чиглэлээр мэдээлэл бэлтгэн танилцуулж, татварын хууль, тогтоомжтой холбоотой асуултанд хариулт өгч оролцов.

БНХАУ, ОХУ, Япон болон Сингапур улсуудын нимгэн капиталжуулалтын татварын туршлагын талаар хууль тогтоомжид тусгасан зүйл заалтуудын талаар судалж, манай улсын ААНОАТ-ын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан зүйл заалтын хэрэгжилт нь татварын орлогод хэрхэн нөлөөлж байгааг тооцон, холбогдох дүрэмд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Харилцан хамааралтай этгээдүүдийн үнийг урьдчилан тохирох зохицуулалтын талаар БНСУ, ОХУ-ын хууль, тогтоомжийг судалж, харьцуулан дүгнэлт хийв. Татварын тааламжтай, албан татвараас чөлөөлөх тогтолцоотой БНСУ, БНХАУ, ОХУ, Итали, БНФУ улсуудын баримталж буй бодлогын талаар мэдээлэл, БНХАУ-ын Татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх дүрмийн захиргааны шалгуур үзүүлэлтүүд, Индонези, Гүрж, Казакстан, Украйн улсуудын татварын хуулинд гадаадын аж ахуйн нэгжийн төлөөний газар болон аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй төлөөлөгчийн газрын талаар тусгасан зүйл заалтуудыг татварын бодлогод ашигласан болно.

Татварын хувь хэмжээ бага, албан татвараас чөлөөлөх тогтолцоотой улс орнуудад байрладаг хяналттай аж ахуйн нэгжүүдэд шилжиж байгаа орлогод хяналт тавих талаар бусад улсуудын баримталж буй бодлогын талаар танилцуулгыг Сангийн яаманд 2017 оны 6 сарын 9-ны өдрийн 01/1748 дүгээр албан бичгээр хүргүүлээ.

Тайлант хугацаанд татварын болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор татварын албаны бүтэц зохион байгуулалттай уялдуулан хугацаатай үүрэг, даалгавар өгсөн 5, аргачлал, заавар, журам, маягт, төлөвлөгөө баталсан 36, тендерийн үнэлгээний хороо, ажлын хэсэг, комисс томилсон 23, хяналт, шинжилгээний дүн, ажил зохион байгуулсан 4, гадаадад хурал, зөвлөгөөнд оролцох, сургалтад хамруулахаар томилсон 15, дотоодын сургалт зохион байгуулсан 1, буцалтгүй тусламж, нөхөн олговор олгосон 5, цалин тогтоох, шагнал урамшуулал олгосон 9, сахилгын шийтгэл ногдуулсан 5, зардал гаргасан 6, бусад чиглэлээр 14, нийт 126 “А” тушаал гарган хэрэгжүүлэв. Тухайлбал ТЕГ-ын даргын А/05 дугаар тушаалаар “Татварын тайлан хүлээн авах, хянах, нэгтгэл хийх журам”, А/06 дугаар тушаалаар “Татвар төлөгчийг бүртгэх журам”, А/84 дугаар тушаалаар “Шилдэг татвар төлөгчийг шалгаруулах, татвар төлөгчийг шагнаж урамшуулах журам”-ыг А/46 “Эрсдэлийн хорооны ажиллах журам”, А/112 дугаар тушаалаар Татварын ерөнхий газрын “Ёслол, хүндэтгэлийн дэг жаягийг тогтоох журам”-ыг баталжээ.

НӨАТ-ын хууль, НХАТ-ын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах “Санамж бичиг”-т 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдөр гарын үсэг зурлаа.

1.2 Гадаад хамтын ажиллагаа, давхар татварын гэрээний талаар

Давхар татварын гэрээ, бусад хэлэлцээрийн хүрээнд ОХУ-ын татварын алба, БНТУ-ын Сангийн яамнаас албан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг хүргүүлсэн байна. Мөн давхар татварын гэрээтэй 25 улс руу “Оршин суугчийн сертификат”-ын загварыг ирүүлэх хүсэлтийг 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 02/1259 дүгээр албан бичгээр хүргүүлэв.

Монгол Улс, Япон Улсуудын хооронд байгуулах давхар татварын гэрээний төсөлд НҮБ, ЭЗХАХБ-ын загвар гэрээ болон бусад Азийн улсуудын Япон Улстай байгуулсан гэрээнүүдийг харьцуулан судалж саналаа Сангийн яаманд хүргүүлэв. Монгол Улс, Япон Улсын хооронд давхар татварын гэрээ байгуулах урьдчилсан уулзалтад оролцож, Монгол Улсын орлогын албан татварын талаар товч танилцуулга хийсэн болно.

Сангийн яам, Европын холбоотой хамтарсан "Эдийн засгийн тэгш өсөлтийг хангах сайн засаглал" төслийн хүрээнд ажиллаж буй төслийн зөвлөхүүдтэй хамтран ажилласан. Төслийн зөвлөхүүд "Давхар татварын гэрээ" сэдэвт сургалтыг 2017 оны 5 сарын 25, 26-ны өдрүүдэд зохион байгуулахад оролцлоо.

Давхар татварын гэрээтэй улс руу шилжүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаарх 2016 оны тоо мэдээллийг гарган 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр цахим шуудангаар Сангийн яаманд хүргүүлсэн болно.

Бүгд Найрамдах Киргиз Улс /БНКУ/-ын төлөөлөгчдийн НӨАТ-ын туршлага судлах талаарх айлчлалыг 9 сард зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

1.3 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар

ЖАЙКА байгууллага болон Монголын татварын албатай хамтран хэрэгжүүлж буй "Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд дараах ажлыг зохион байгууллаа.

Төслийн 2 дахь шатны үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан хөндлөнгийн суурь судалгааны багтай хамтран 2017 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс 3 дугаар сарын 23-ны өдрүүдэд ажиллаж, шаардлагатай тоон мэдээллээр хангав.

Төслийн удирдах хорооны гишүүдийг ТЕГ-ын 2017 оны А/77 дугаар тушаалаар томилж, анхдугаар хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 14-ны өдөр зохион байгуулсан байна.

Төслийн зөвлөхүүдтэй уулзалт хийж, Чингэлтэй, Сонгинохайрхан Татварын хэлтсийн үйл ажиллагааг танилцуулав.

Төслийн хүрээнд Япон Улсад зохион байгуулагдсан "Татварын ерөнхий газрын чадавхыг бэхжүүлэх нь" сэдэвт сургалтад 15 албан хаагчийг хамруулсан болно.

ОУВС, АНУ-ын төрийн сангийн шугамаар хэрэгжиж байгаа "Татварын удирдлагын шинэчлэлт" төслийн хүрээнд "Бичил, жижиг болон дунд хэмжээний бизнес эрхлэгчийн татварын удирдлагыг боловсронгуй болгох" чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.

ОУВС-ын Төсвийн асуудал эрхлэх газартай хамтран ажиллах санамж бичигт 2017 оны 2 сарын 9-ний өдөр гарын үсэг зурж, "Төслийн удирдах хороо"-г байгууллаа.

Төслийн хүрээнд "Сегментийн ангилал, үйл ажиллагааны журам", "Сегментийн үйл ажиллагааны стратеги", "Сегментийн үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх төлөвлөгөө", "Үнэлгээний шалгуур үзүүлэлтийн маягтыг ТЕГ-ын даргын 2017 оны А/92 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

ОУВС-ын "Техникийн туслалцааны баг"-т төслийн хэрэгжилтийн явцын талаар танилцуулга хийж, ТЕГ-ын удирдлагын өгөх үнэлгээний саналыг ОУВС-ынтөв оффист хүргүүлсэн болно. Түүнчлэн ОУВС-ийн Захирлуудын зөвлөлийн хуралд татвар төлөгчийн сегментүүдийн хууль, тогтоомж мөрдөлтийг сайжруулах стратегийн хэрэгжилтийн талаар танилцуулга хийлээ.

Сегментийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах удирдагчаар томилогдсон байцаагч, НТГ-ын удирдлагууд, дүүргийн татварын хэлтсийн татварын улсын ахлах байцаагчид болон Эрсдэл статистик хариуцсан нэгжийн байцаагчид 2017 оны 3 дугаар сарын 9-ний өдөр "Сегментэд тулгуурлан хууль, тогтоомж мөрдөлтийг удирдах ажиллагааг МТА-нд нэвтрүүлэх нь" сэдэвт сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулжээ.

Сегментийн үйл ажиллагааны удирдлагын мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний ажлыг автоматжуулах ажлыг хийж байна.

Хоёр. Стратегийн зорилт 2.4.2. "Татварын албаны үйл ажиллагаанд мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, татварын албаны цогц мэдээллийн системийг бий болгох, үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, бүртгэлийг боловсронгуй болгох, татвар төлөгчид шуурхай үйлчилгээ үзүүлэх, статистик болон хөндлөнгийн мэдээллийн сангийн ашиглалтыг дээшлүүлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт шалгалтын тогтолцоог зах зээлийн сегмент тус бүрээр олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах замаар татварын суурийг өргөжүүлэх, далд эдийн засгийг бууруулах, улс орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх, татварын өр барагдуулах түвшинг дээшлүүлэх" хүрээнд;

2.1 Татварын мэдээ, мэдээлэл, статистикийн талаар

УИХ, ЗГ, Сангийн Яам болон төрийн бусад байгууллага, хууль, хяналтын байгууллага, дотоод бүтцийн нэгжүүдийн албан хүсэлтийн дагуу нийт 384 мэдээ, мэдээлэл, судалгаа, лавлагааг боловсруулж хүргүүлсэн байна. Тухайлбал

- УИХ-ын Тамгын газарт эдийн засгийн салбарын ангилал, хуулийн заалт тус бүрээр гарсан 2016 он, 2017 оны эхний 4 сарын байдлаар ААНОАТ, ХХОАТ, НӨАТ-н тайлангийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн графикт мэдээг;
 - ХХААЯ-нд 2012-2016 оны аж ахуй нэгжийн орлогын албан татварын тайлангийн борлуулалтын орлого нь 1.5 тэрбумаас доош, тасралтгүй 5 жил үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжийн борлуулалтын орлогыг 4 шатлалаар, татвар төлөгч тус бүрээр ангилсан судалгаа, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\ -ын татварын төлөлтийн мэдээллийг салбарын ангиллаар гаргасан судалгаа, жижиг дунд үйлдвэрийн тоног, төхөөрөмж оруулж ирсэн аж ахуйн нэгжийн 2014-2015 оны борлуулалтын орлого, татвар төлөлтийн шатлалын салбарын ангилал, татвар төлөлтийн мэдээллийг;
 - БОАЖЯ-нд аймаг, нийслэлийн хэмжээнд төвлөрүүлсэн ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн 2016 оны гүйцэтгэлийн мэдээ, ААНОАТ-ийн хуулийн 18.1.8-д заасан "Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан" татвар төлөгчдийн мэдээллийг;
 - Үндэсний статистикийн хороонд 2011-2015 оны АТБӨЯХАТ төлөлтийн мэдээллийг татвар төлөгч тус бүрээр, үндэсний тооцоонд ашиглах ААНОАТ-ын тайлан, татвар төлөлтийн мэдээллийг;
 - Туул голын сав газрын захиргаанд Нийслэлийн болон Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Архангай, Булган аймгуудын усны нөөц ашигласны төлбөрийн гүйцэтгэлийн 2016 оны мэдээллийг;
 - УИХ-ын гишүүн н.Аюурсайханд дизелийн түлш, бензин импортлогч аж ахуйн нэгжүүдийн 2011-2016 оны ААНОАТ-ын тайлангийн мэдээллийг;
 - ГХЯ-нд 2016 онд 500.0 саяас дээш төгрөгийн татвар төлсөн аж ахуйн нэгжийн жагсаалтыг;
 - МХААҮТ-д "ТОП-100" аж ахуйн нэгжийг шалгаруулахтай холбогдуулан хамгийн их борлуулалтын орлоготой, хамгийн их татвар төлсөн 500 аж ахуйн нэгжийн судалгааг тус тус хүргүүлсэн.
- Мөн 2017 оны эхний хагас жилд Шүүх, АТГ, Цагдаа, хуулийн байгууллага, Яам, тамгын газруудаас лавлагаа, судалгаа гаргуулах хүсэлт ирүүлсэн 292 албан бичгийн хариуг хугацаанд хүргүүлэв.

Олон улсын валютын сангаас Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтэд судалгаа /Gap analyses/ хийх бэлтгэл ажлын хүрээнд 2007-2016 оны НӨАТ-ын орлогын талаарх мэдээлэл, 2012-2016 оны НӨАТ-ын хөнгөлөлт, НӨАТ-ын тэг хувь, хэмжээ, НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн татвар төлөгчийн тоо, бүртгэлийн тоо зэрэг мэдээллийг гарган болон бусад мэдээллийг дотоод бүтцийн нэгжүүдээс гаргуулан авч нэгтгэн ТУХАГ-т хүргүүлсэн. ОУВС-ийн ахлах эдийн засагч ЭрикХаттонтай хамтран ажиллаж НӨАТ-ын "gap" анилиз хийхэд шаардагдах 2007-2016 оны НӨАТ-ын тайлан, татвар төлөлт, татварын тооцоолол, татвар төлөгчийн бүртгэл, Гаалийн мэдээллийг ГТСМТТ-УТҮГ-тай хамтран гаргаж татвар төлөгчийн нууцлалыг хангах үүднээс шифрлэн хүргүүлсэн.

"Бичил, жижиг болон дунд хэмжээний бизнес эрхлэгчийн татварын удирдлагыг боловсронгуй болгох нь" төслийн хүрээнд VI системд татвар төлөгчдийг сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого болон дүрмийн сангийн дүнгээр нь бичил, жижиг, дунд, том сегментээр ангилан бааз үүсгэж татварын албаар болон нэгдсэн байдлаар удирдлагын мэдээллийн репортийг бэлдэж дотоод бүтцийн нэгжүүд болон сегментийн ажлын хэсэг, сегментийн удирдагч нар ашиглахад бэлэн болгосон.

Статистикийн мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангах, илрүүлсэн алдааг холбогдох нэгжид мэдэгдэн засварлуулах арга хэмжээ авах ажлын хүрээнд ААНОАТ-ын 2016 оны 4-р улирлын 42 татвар төлөгчийн 84 тайлан, 2017 оны 1-р улирлын 1950 татвар төлөгчийн 4000 гаруй тайлан давхардсаныг засварлуулав. УТОХГ-ын 2016 оны татварын орлогын гүйцэтгэлийн 3 тэрбум төгрөгөөр зөрүүг ГТСМТТ-УТҮГ-т мэдэгдэн залруулах арга хэмжээ авлаа. 2017 оны 1-р улирлын ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тайланг нэгтгэх явцад хуулийн зүйл заалт андуурч тайлан ирүүлсэн 2 татвар төлөгчийн тайлангийн алдааг илрүүлэн Хэнтий аймаг, Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст, 2017 оны 4-р сарын Дарсны онцгой албан татварын тайланг нэгтгэх явцад Сонгинохайрхан дүүргийн 1 татвар төлөгч тайланг алдаатай илгээснийг татварын албанд мэдэгдэн засварлуулсан.

Удирдах дээд байгууллага, татварын албадыг татварын статистикийн мэдээллээр хангах зорилгоор 2016 оны 12 сар, 2017 оны 1-5 сарын орлогын мэдээ, Онцгой албан татварын тайлангийн ирц, нэгтгэлийн мэдээллийг төрөл тус бүрээр, НӨАТ-ын тайлангийн ирц, нэгтгэл, 2016 оны жилийн эцэс, 2017 оны 1 дүгээр улирлын ААН-ийн бүртгэлийн товчоог татварын албаар болон хариуцлагын хэлбэрээр, ААН-н бүртгэлийн хөдөлгөөний мэдээ, ААНОАТ-ын тайлангийн ирц, нэгтгэл, хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ, борлуулалтын орлогын товчоо, хувь хэмжээний товчоо, АМНАТ-ын тайлангийн ирц, нэгтгэл, Хяналт шалгалтын мэдээ, Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлангийн ирц, нэгтгэл, Суутгагчийн хувь хүнд олгосон тайлангийн нэгтгэл, АТБӨЯХАТ -ын нэгтгэл, үл хөдлөх хөрөнгийн албан татварын тайлангийн нэгтгэл, бууны албан татварын тайлангийн нэгтгэл, Татварын тооцооллын тайлангийн болон хяналт

шалгалтын товчоо, Нийслэл хотын албан татварын тайлангийн нэгтгэл, ирцийн мэдээ гэх мэт нийт 128 мэдээг гарган ТЕГ статистик мэдээний санд байршууллаа. Түүнчлэн Татварын ерөнхий газрын даргын баталсан бүртгэл, татварын тайлан, мэдээний маягтын нэгдсэн сан үүсгэж, татвар төлөгчийн бүртгэлийн маягт 23, татварын тайлан, хавсралт мэдээний маягт 94, дотоод үйл ажиллагааны маягт 116, нийт 233 бүртгэл, тайлан, мэдээний маягтыг байршуулаад байна.

1993 оноос 2017 оны 4-р сарыг дуустал хугацааны Статистик мэдээллийн санг зөврийн дискэнд архив бааз үүсгэн сүлжээнээс салган аюулгүй байдлыг ханган хадгалсан.

"Монгол Улсын татварын статистикийн эмхэтгэл 2012-2016" номны эх бэлтгэлд шаардлагатай 2012-2016 оны татвар төлөгчийн бүртгэл, татварын тайлан, хөнгөлөлт, чөлөөлөлтийн мэдээ, татвар төлөлтийн болон дотоод статистик болох хүний нөөцийн, байцаагчдийн сургалтын мэдээллийг бэлтгэж Монгол такстин ХХК-д хүргүүлэв.

"Харьяа татварын нэгжийн эрсдэл, статистикийн асуудал хариуцсан хэлтэс, тасгийн статистикийн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын зөвлөмж"-ийг боловсруулан татварын албадад албан бичгээр хүргүүлсэн болно.

2.2 Програм хангамж, компьютер, төхөөрөмжийн засвар үйлчилгээний талаар

Тайлангийн хугацаанд програмын хөгжүүлэлт хийсэн 8, хөгжүүлж байгаа 5, нийт 13 програм байна. Үүнээс нэвтрүүлэх буюу ашиглуулж эхлэх 7 програм байна. Системийн 241 алдааг засварлахаас хэрэглэгчийн буруутай үйлдлээс шалтгаалсан 142 алдааг засварлав. Тухайлбал аймаг, дүүргийн татварын албадын аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэр, регистрийн дугаар, баримт бичгийг хянаж ТРИПС системд 104 аж ахуйн нэгжийн татварын бүртгэлийн алдааг засварласан байна.

Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлын төлбөр, Зам ашигласны төлбөрийг хураах үйл ажиллагаанд цахим төлбөр тооцооны систем ашиглах ажлын хүрээнд Нийслэлийн мэдээллийн технологийн газартай хамтран ажиллаж байна. Татвар төлөгч иргэд, аж ахуйн нэгжүүд smartcar.mn цахим хуудсыг ашиглан дурын банкны картыг ашиглан төлбөр төлөх боломжтой болно. Төлөх татварын мэдээллийг Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн систем автоматаар ногдол үүсгэж, банкны систем руу дамжуулснаар төлбөр хийгдсэн тухай мэдээллийг цаг хугацаа алдахгүй шууд хүлээн авч Татвар бүртгэлийн нэгдсэн мэдээллийн санд бүртгэх боломж бий болно. Уг системийг 2017 оны 7 сарын 1-нээс Нийслэл хотын хэмжээнд нэвтрүүлнэ.

Монгол улсын нийтийн түлхүүрийн дэд бүтэцтэй Цахим тайлангийн системийг холбон тайлан хүлээн авч баталгаажуулахад нэгдүгээрт тоон гарын үсэг ашиглан хэрэглэгч нэвтрэх, хоёрдугаарт татварын тайланд захирал, нягтлан хоёрыг зэрэг цахим гарын үсэг зурах боломжтой болсон. Монгол улсад нийтийн түлхүүр бүрэн нэвтрэх хүртэл одоо олгож байгаа татварын тоон гарын үсэг болон монгол улсын цахим гарын үсгийг хамтад нь Цахим тайлангийн систем ашиглан тайлан баталгаажуулахаар системийг хөгжүүлж бэлэн болгоод байна. 2017 оны хагас жилийн тайлан хүлээн авах үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд бэлэн боллоо.

Хяналт шалгалтын 2017 оны төлөвлөгөө батлахтай холбогдуулан Fisher системд эрсдэлийн тооцоолол хийхэд шаардлагатай мэдээллийг боловсруулж, эрсдэлийн тооцооллыг бодуулах хөгжүүлэлтийг хийв.

Татварын ногдол, өр дуудах төвийн програм, татварын тайлан боловсруулалтын програм, ухаалаг тайлангийн систем, цахим төлбөрийн баримтын систем, татварын удирдлагын системийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр ГТСМТТ-тэй хамтран ажиллаж байна.

Татварын албаны компьютер, тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг оношилж, холбогдох 416 засвар үйлчилгээг хийлээ.

Татварын ерөнхий газар, ГТСМТТУТҮГ, Үндэсний дата төв ашиглагдаж байгаа мэдээлэл технологийн зориулалт бүхий компьютер болон бусад тоног төхөөрөмжийн тооллогыг хийж судалгааг гаргасан болно.

Орон нутгийн онлайн холболтыг Layer 3 технологи руу шилжүүлэх ажлын туршилтыг амжилттай хийлээ. Тус технологи руу Налайх, Багануур, Багахангай дүүргийн татварын хэлтэс, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн татварын хэлтсийн сүлжээ бүрэн шилжээд байна. Энэхүү сүлжээний өөрчлөлт хийснээр орон нутгийн сүлжээг ТЕГ-ээс хянах боломжууд сайжирч байна.

2.3 Татвар төлөгчийн бүртгэлийн талаар.

ОӨУБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газартай хамтарсан хуулийн этгээдийн бүртгэлийг татварын төлөгчийн бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах ажлын удирдамжийг ТЕГ-ын дарга болон ОӨУБЕГ-ын даргын 2017 оны A/118 / A/540 дугаар тушаалаар батлав. Тус газраас 6984 хуулийн этгээдийн мэдээллийг хүлээн авч, татварын албадад хүргүүлээ. Тайлант хугацаанд 3630 аж ахуйн нэгж байгууллага бүртгүүлэхээс 3232 аж ахуйн нэгж байгууллага татварын албанд бүртгүүлж, 398 аж ахуйн нэгжийг бүртгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.

Татварын албанд 2017 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар 161'870 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс УТОХГ-г бүртгэлтэй 434 татвар төлөгч, Нийслэл, дүүргийн татварын албаны хэмжээнд 120'258 татвар төлөгч, аймгийн татварын албаны хэмжээнд 41'178 татвар төлөгч тус тус бүртгэлтэй байна.

| Татварын алба | Татвар төлөгчийн тоо | | | | | | | | Нийт |
|----------------|----------------------|---------|-----------|---------|---------|-------|--------|-------|---------|
| | ХК | ХХК | Нөхөр лөл | Хоршо о | Салба р | ТБ | ТББ | Бусад | |
| Нийт дүн | 327 | 119,328 | 3,577 | 4,431 | 8,337 | 5,208 | 15,872 | 4,790 | 161,870 |
| Аймгийн дүн | 176 | 22,635 | 1,936 | 3,542 | 3,742 | 3,789 | 3,778 | 1,580 | 41,178 |
| Нийслэлийн дүн | 111 | 96,342 | 1,640 | 888 | 4,595 | 1,417 | 12,092 | 3,173 | 120,258 |
| УТОХГ-ын дүн | 40 | 351 | 1 | 1 | 0 | 2 | 2 | 37 | 434 |

Бусад* (сан, шашны байгууллага, хад.зээлийн хоршоо, ОНӨҮГ, ХХН, ТӨҮГ, төлөөлөгчийн газар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, элчин сайдын яам, боловсрол сургалтын байгууллага, давхар нэгж, төлөөний газар)

| Татварын алба | 2016.01.01-ны өдөр | Нэмэгдсэн | Хасагдсан | 2016.11.30-ны өдөр |
|----------------|--------------------|-----------|-----------|--------------------|
| Нийт | 156'692 | 12'477 | 7'321 | 161'868 |
| Аймгийн дүн | 39'110 | 2'510 | 443 | 41'180 |
| Нийслэлийн дүн | 117'156 | 9'959 | 6'877 | 120'255 |
| УТОХГ нийт | 426 | 8 | 1 | 433 |

Татварын албаны хэмжээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар нийт 156'692 аж ахуйн нэгж байснаас 12'477 аж ахуйн нэгж нэмэгдэж, 7'321 аж ахуйн нэгж хасагдаж 161'868 аж ахуйн нэгж байгууллага байна.

НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх "босго"-ыг борлуулалтын орлогын хэмжээ нь 50.0 сая төгрөг ба түүнээс дээш төгрөгт хүргэн нэмэгдүүлсэн хэдий ч цахим төлбөрийн систем, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлснээр 631 НӨАТ суутган төлөгч шинээр нэмэгдэв.

Татварын албаны 2017 оны Татвар төлөгчийн бүртгэлийг сайжруулах зорилтын хүрээнд татвар төлөгч иргэн аж ахуйн нэгжийн тооллогыг 2017 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Татвар төлөгчийг бүртгэх журмын дагуу 122 хуулийн этгээд харьяалал шилжих хүсэлт ирүүлсэнээс 109 хуулийн этгээдийг шилжүүлж, 13 хуулийн этгээдийг нэмэлт материал ирүүлэх тухай албан бичгийг татварын албадад хүргүүлэв.

2.4 Татварын тайлан хүлээн авалт, тайлангийн ирцийн талаар

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2016 оны 4 дүгээр улирлын тайланг 121'209 ирүүлэхээс 88'258 ирүүлж, ирц 73.0 хувьтай, ирсэн тайлангийн 45.8 хувь буюу 37'962 нь "Х" болон "алдагдалтай" тайлан байна. 2017 оны 1 дүгээр улирлын тайланг 123'968 ирүүлэхээс 82'210 ирүүлж, ирц 66.32 хувьтай, ирсэн тайлангийн 55.3 хувь буюу 44'604 нь "Х" болон "алдагдалтай" тайлан байна. "Х" болон "алдагдалтай" тайланг 2016 оны жилийн эцэс болон 2017 оны 1 дүгээр улирлын байдалтай харьцуулан авч үзвэл 0.85 хувиар өссөн байна.

Хувь хүний орлогын албан татвар /Суутган-1/-ын 2016 оны 4 дүгээр улирлын тайланг 136'657 ирүүлэхээс 96'133 ирүүлж, ирц 70.4 хувьтай, ирсэн тайлангийн 60.7 хувь буюу 58'373 "Х" болон "алдагдалтай" тайлан байна. 2017 оны 1-р улирлын тайланг 138'504 ирүүлэхээс 91'210 ирүүлж, ирц 65.84 хувьтай, ирсэн тайлангийн 64.1 хувь буюу 58'493 "Х" болон "алдагдалтай" байна. "Х" болон "алдагдалтай" тайланг 2016 оны жилийн эцэс болон 2017 оны 1 дүгээр улирлын байдалтай харьцуулан авч үзвэл 0.85 хувиар өссөн дүнтэй байна.

2016 оны 4-р улирлын тайлангийн ирц:

| Татварын төрөл | Ирүүлбэл зохих | Ирүүлсэн | Хүлээн авсан | Ирцийн хувь | Тайлан ирүүлээгүй | X тайлан |
|---------------------------|----------------|----------|--------------|-------------|-------------------|----------|
| ААНОАТ | 121'209 | 88'258 | 82'829 | 72.8 | 32'951 | 37'962 |
| ЦХБТАОСАТТ \Суутган-1\ | 136'657 | 96'133 | 96'061 | 70.4 | 40'524 | 58'373 |
| СХХООСАТТ | 11'223 | 9'685 | 9'655 | 86.3 | 1'538 | 2'780 |
| ОАТТ | 54 | 51 | 49 | 96.5 | 3 | 35 |
| Бусад | 77'063 | 40'417 | 37'294 | 92.1 | 36'871 | 10'619 |

2017 оны 1-р улирлын тайлангийн ирц:

| Татварын төрөл | Ирүүлбэл зохих | Ирүүлсэн | Хүлээн авсан | Ирцийн хувь | Тайлан ирүүлээгүй | X тайлан |
|-----------------------|----------------|----------|--------------|-------------|-------------------|----------|
| ААНОАТ | 123'968 | 82'210 | 80'650 | 66.3 | 44'695 | 44'604 |
| ЦХБТАОСХТТ\Суутган-1\ | 138'504 | 91'210 | 91'192 | 65.8 | 47'387 | 58'493 |
| СХХООСАТТ | 12'170 | 9'108 | 9'103 | 74.8 | 3'062 | 5'021 |
| Бусад | 32'992 | 3'339 | 1'630 | 10,1 | 29'653 | 373 |

Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 2016 оны 4 дүгээр улирлын тайланг 11'223 ирүүлэхээс 9685 ирүүлж, ирц 86.3 хувьтай, "X" болон "алдагдалтай" тайлан 2'780 буюу 28.7 хувь нь ирүүлжээ. 2017 оны 1 дүгээр улирлын тайланг 12'170 ирүүлэхээс 9'108, ирүүлж, ирц 74.8 хувьтай, үүнээс "X" болон "алдагдалтай" тайлан 5'021 буюу 55.2 хувьбайгаа нь өмнөх хугацааны тайлангийн ирцээс өссөн үзүүлэлтэй байна.

НӨАТ-ын тайлан, 2017 оны 1-5 дугаар сарын тайлангийн ирц нь нийт үзүүлэлтээр тайлан ирүүлбэл зохих 32'801 татвар төлөгчөөс 17'996 тайлан хүлээн авч, тайлан хүлээн авалт системийн дүнгээр 82.4 хувьтай байна.

2017 оны 1-5 сарын НӨАТ- тайлангийн ирц

| Хугацаа /сараар/ | Ирүүлбэл зохих | Ирүүлсэн | Хүлээн авсан | Ирцийн хувь |
|------------------|----------------|----------|--------------|-------------|
| 2017.01 | 33'082 | 26'785 | 26'004 | 85.2 |
| 2017.02 | 32'620 | 27'233 | 4'341 | 83.4 |
| 2017.03 | 32'681 | 26'923 | 24'097 | 82.3 |
| 2017.04 | 32'855 | 26'827 | 12'967 | 81.6 |
| 2017.05 | 32'769 | 26'785 | 22'569 | 81.7 |
| Нийт | 32'801 | 26'911 | 17'996 | 82.4 |

Онцгой албан татварын тайлангийн ирц 2016 оны 12 дугаар сар, 2017 оны 1-5 дугаар сарын тайлангийн ирц нь тайлан ирүүлбэл зохих 49 татвар төлөгчөөс 46 тайлан хүлээн авч, системийн дунджаар 95.0 хувьтай байна.

2017 оны 1-5 сарын Онцгой албан татварын тайлангийн ирц

| Хугацаа /сараар | Ирүүлбэл зохих | Ирүүлсэн | Ирцийн хувь |
|-----------------|----------------|-----------|-------------|
| 2016.12 | 67 | 65 | 97.0 |
| 2017.01 | 49 | 45 | 91.8 |
| 2017.02 | 23 | 22 | 95.7 |
| 2017.03 | 51 | 49 | 96.1 |
| 2017.04 | 57 | 52 | 91.2 |
| 2017.05 | 48 | 47 | 97.9 |
| Нийт | 49 | 46 | 93.9 |

Бусад татварын төрөл буюу 2016 оны жилийн эцсийн тайлан АМНАТ ба бусад тайлангийн ирцийг авч үзвэл ирүүлбэл зохих 77'063 тайлангаас ирүүлсэн 40'417 тайлан ирүүлэн 92.1 хувьтай байна. Үүнээс Х" болон "алдагдалтай" тайлан 10'619 буюу 28.1 хувьтай байна. 2017 оны 1-р улирлын тайлангийн ирцийг авч үзвэл ирүүлбэл зохих 32'992 ирүүлсэн 3'339 тайлан ирүүлэн 10.1% нь тайлан ирүүлэн Үүнээс Х" болон "алдагдалтай" тайлан 373 буюу 0.11 хувьтай байна.

2.5 НӨАТ-ын цахим баримт бүрдүүлэлт, урамшууллын талаар

Тайлант оны эхний 5 сарын байдлаар бизнес эрхлэгч 76'990 татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээд стандартын шаардлага хангасан бүртгэлийн машин, цахим системд холбогдож, мэдээллээ төлбөрийн баримтын нэгдсэн системд илгээсэн байна. Дээрх 76'990 татвар төлөгчдөөс 43751 буюу 56.8 хувь нь цахим баримтаа идэвхтэй хэвлэж байна. 2017 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 293,5 сая ширхэг баримт илгээгдэж, 150,0 сая ширхэг баримт буюу 51.1 хувийг татвар төлөгчид баталгаажуулсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханган албан татвар төлөгчийн 2016 онд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэлх хувийг буцаан олгох ажлыг анх удаа зохион байгуулав. Энэ ажлын дүнд 620'409 татвар төлөгч иргэнд 35.5 тэрбум төгрөгийг буцаан олгохоос 497'513 татвар төлөгч иргэнд 35.1 тэрбум төгрөг буюу мөнгөн дүнгээр 98.7 хувийг олгосон байна. Түүнчлэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журмын дагуу 5 удаагийн сугалааг зохион байгуулжээ. Сугалаагаар 53'961 азтанд 2'038.8 сая төгрөгийн урамшуулал олгохоос 41'875 азтаны 1'637.2 сая төгрөгийн урамшууллыг олголоо.

Татвар төлөгчийн цахим төлбөрийн баримт хэвлэж байгаа, системд илгээж байгааг хянах зорилгоор гар утсанд Tax inspector аппликейшн суулгах ажлыг зохион байгуулав. Тус аппликейшнийг нийслэлийн хэмжээний татварын албадын 648 байцаагчийн гар утсанд суулган ашиглаж байна.

2.6 Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний талаар

Татварын алба 2017 онд улс, орон нутгийн төсөвт 2766.4 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс улсын төсөвт 1907.4 тэрбум, орон нутгийн төсөвт 859.0 тэрбум төгрөгийн татварын орлого тус тус төвлөрүүлнэ. Улсын төсөвт 2017 онд төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөөний хуваарийг ТЕГ-ын даргын 2017 оны А/19, А/106 оны дугаар тушаалаар батлан, татварын албадад хүргүүлжээ.

Урд оны төлөвлөгөөнөөс улсын төсвийн татварын орлогын төлөвлөгөө 517.2 тэрбум төгрөг буюу 37.2 хувиар, орон нутгийн төсвийн татварын орлогын төлөвлөгөө 60.8 тэрбум төгрөг буюу 7.6 хувиар өссөн байна.

Улс, орон нутгийн төсөвт 2017 оны эхний 6 сард 1645.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1749.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 106.3 хувиар биелүүллээ. **Улсын төсөвт** 1205.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1283.8 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 106.5 хувиар биелүүлэв. Улсын төсвийн орлогын биелэлтийг татварын нэр төрлөөр нь авч үзвэл:

- ААНОАТ-ын орлогын төлөвлөгөөний биелэлт 110.4 хувь,
- НӨАТ-ын орлогын төлөвлөгөөний биелэлт 106.3 хувь
- АМНАТ-н төлөвлөгөөний биелэлт 102.5 хувь,
- Онцгой албан татварын төлөвлөгөөний биелэлт 106.0 хувь,
- Агаарын бохирдлын төлбөр төлөвлөгөөний биелэлт 118.6 хувиар биеллээ.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татварын орлого нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 566.2 тэрбум төгрөг буюу 78.9 хувиар өссөн байна.

Орон нутгийн төсөвт 439.8 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлэхээс 465.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 105.9 хувиар биелүүллээ.

Тайлант хугацаанд 132 татвар төлөгчийн 1.3 тэрбум төгрөгийн төсөв доторх орлогын залруулга, 86 татвар төлөгчийн 1.4 тэрбум төгрөгийн төсвөөс гарсан зарлага, нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтоор нийт 23 татвар төлөгчийн 26.6 тэрбум төгрөгийн буцаан олголтыг татвар төлөгчид болон татварын өрөнд тооцон төсвөөс шилжүүлснийг Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэв.

2.7 Татварын өр, тайлант оны ногдлыг барагдуулах ажлын талаар.

Тайлант хугацаанд урд оны татварын өрийн үлдэгдэл болон тайлант оны ногдлын нийт 2'173.1 тэрбум төгрөгөөс 1'359.1 тэрбум төгрөг буюу 62.5 хувийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Урьд оны 1'082.5 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдлээс 543.3 тэрбум төгрөг буюу 50.2 хувийг барагдуулсан бол

Урьд оны өрийн барагдуулалт:

(тэрбум төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2016.12.31-ний үлдэгдэл | Барагдуулалт | | 2017.06.30-ны үлдэгдэл |
|-------------------------------|----------------------------|--------------|------|---------------------------|
| | | Дүн | Хувь | |
| Нийт үлдэгдэл | 1082.5 | 543.3 | 50.2 | 539.2 |
| Тайлангийн ногдол | 983.9 | 523.5 | 53.2 | 460.4 |
| Хяналт шалгалтын актын ногдол | 98.6 | 19.8 | 20.0 | 78.8 |

Тайлант хугацаанд ногдуулсан 1090.6 тэрбум төгрөгөөс 815.8 тэрбум төгрөг буюу 74.8 хувийг барагдуулсан байна.

Тайлант оны барагдуулалт:

(тэрбум төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2017.06.30-ны байдлаар ногдол | Барагдуулалт | | 2017.06.30-ны үлдэгдэл |
|-------------------------------|-------------------------------------|--------------|------|---------------------------|
| | | Дүн | Хувь | |
| Нийт үлдэгдэл | 1090.6 | 815.8 | 74.8 | 274.8 |
| Тайлангийн ногдол | 1024.5 | 783.2 | 76.4 | 241.3 |
| Хяналт шалгалтын актын ногдол | 66.1 | 32.6 | 49.3 | 33.5 |

Тайлант онд барагдуулаагүй 814.0 тэрбум төгрөгийн татварын өрийн үлдэгдлээс 187.7 тэрбум төгрөг буюу 23.0 хувийг хүндрэлтэй өр эзэлж байна.

Татварын өр барагдуулах чиглэлээр дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

- Татварын ерөнхий газрын даргын 2011 оны 729 дүгээр тушаалаар баталсан “Татвар хураах үйл ажиллагааны журам”-д заасны дагуу 2016 оны 12 сарын 31-ний байдлаар ТБМНС-д бүртгэлтэй татварын тооцооллын үлдэгдлийг “Цахим татварын систем”-ээр дамжуулан татвар төлөгчтэй тооцоо нийлэх ажлыг зохион байгуулав. Өмнөх жилүүдэд зөвхөн татвар төлөгч хуулийн этгээдийн татварын тооцооллын үлдэгдлийг баталгаажуулж байсан бол энэ жил татвар төлөгч иргэний татварын тооцооллын үлдэгдлийг баталгаажуулахын зэрэгцээ ТБМНС-ийн мэдээллийн баазыг цэгцлэх ажилд анхаарч ажилласан болно. Энэ ажлын дүнд 2017.06.28-ны өдрийн байдлаар 326'215 татвар төлөгч тооцооллын үлдэгдлээ баталгаажуулахаас 267'452 татвар төлөгч буюу 82.0 хувь нь зөвшөөрсөн, 6'649 татвар төлөгч буюу 2.0 хувь нь зөвшөөрөөгүй, 52'114 татвар төлөгч буюу 16.0 хувь нь хариулаагүй ба нийт татвар төлөгчдийн 84.0 хувь нь үлдэгдлээ баталгаажуулсан байна. Үүнээс нийт 100'012 хуулийн этгээдийн 85'532 буюу 86.0 хувь нь зөвшөөрсөн, 4498 буюу 4.0 хувь нь зөвшөөрөөгүй, 9'982 буюу 10.0 хувь нь хариулаагүй, 226'203 иргэний 181'920 буюу 80.0 хувь нь зөвшөөрсөн, 2'151 буюу 1.0 хувь нь зөвшөөрөөгүй, 42'132 буюу 19.0% хариулаагүй ба нийт хуулийн этгээдийн 90.0 хувь, иргэний 81.0 хувь нь татварын тооцооллын үлдэгдлээ баталгаажуулсан байна. Татварын албад тооцооллын үлдэгдэл баталгаажуулах ажлыг 63.2%-99.5%-аар гүйцэтгэлээ.

- Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4.3-т зааснаар татварын албаны даргын тушаалын дагуу 2017 оны эхний хагас жилд 258 татвар төлөгчийн 114.9 сая төгрөгийн хүү, 2'336.7 сая төгрөгийн торгууль, 730.2 сая төгрөгийн алданги, нийт 3'181.8 сая төгрөгийн хүү, торгууль, алдангийг чөлөөлөхөөр ТБМНС-д бүртгэв.

- ШШГА-д байгаа татварын өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2 байгууллагын хамтарсан ажлын уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах гэрээг 2017 оны 4 сарын 19-ний өдөр байгуулан ажиллаж байна. ШШГА-нд ажиллагаа хийгдэж байгаа 685 татвар төлөгчийн 40.9 тэрбум төгрөгийн өрөөс 226 татвар төлөгчийн 2.5 тэрбум төгрөг буюу 6.1 хувь барагдсан байна.

- Сангийн яамнаас албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хуучин загварын онцгой албан татварын тэмдгийг шинэ загварын тэмдгээр солих ажлыг зохион байгуулах чиглэлийг татварын алба болон онцгой албан татвар төлөгч аж ахуйн нэгжид хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан болно. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны төлбөр хураах ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг батлан хэрэгжүүлээ. Үүний дүнд 454.0 мянган тээврийн хэрэгсэл эзэмшигчээс 24.8 тэрбум төгрөгийн албан татвар, 1.4

тэрбум төгрөгийн агаарын бохирдлын төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн нь нийт тээврийн хэрэгслийн 61.8 хувь нь хамрагдсан байна. Албан татвар, төлбөрт хамрагдаагүй 280.0 мянган тээврийн хэрэгслийг хамруулах, татварын орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар харьяа татварын албанд чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

- Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн 2013 оны 24/А-9 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам” дагуу Төрийн сангийн газартай хамтран, арилжааны 11 банкттай хийсэн 3 талт гэрээг дүгнэлээ. Нийслэлийн хэмжээнд автотээвэр болон өөрөө явагч хэрэгслэлийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, авто зам ашигласны хураамжийг хураан төвлөрүүлэхэд шаардлагатай төсвийн татварын орлогын “тэг” үлдэгдэлтэй 46 дансыг арилжааны банкинд нээж, татварын алба, татвар төлөгчид мэдэгдэв. Мөн Нийслэлийн засаг дарга, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 06/01-17/01 дугаар санамж бичгийн 3.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дүүргийн татварын хэлтсээс Нийслэлийн татварын газарт татвар төлөгчдийг шилжүүлсэнтэй холбогдуулан Нийслэлийн татварын газарт шаардлагатай татварын орлогын “0” үлдэгдэлтэй 38 дансыг арилжааны 5 банкинд нээсэн байна.

2.8 Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн талаар

ХХОАТ-ын тайлан, хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал хүлээн авах чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж 257 албан хаагчийг хамруулж, дотоод бүтцийн нэгжүүдэд хэлэлцүүлэг зохион байгуулан, аймаг, нийслэл, дүүргийн татварын албадад 2 удаа заавар чиглэл хүргүүлээ. ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн гарын авлага 25000 ширхэг хэвлүүлэн албадад хуваарилан хүргүүлсэн болно.

ХХОАТ тайлан гаргах чиглэлээр нийт 24631 бизнес эрхлэгчдэд ажлын байран дээрх сургалт зохион байгуулж, утсаар болон биечлэн 28950 татвар төлөгчдөд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ ажлын үр дүнд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт чөлөөлөлт, тайлагнал, буцаан олголтын талаар татвар төлөгчдийн мэдлэг дээшилж хамрах хүрээ өмнөх жилийнхээс нэмэгдэж ирүүлсэн тайлангийн тоо өссөн, орон сууцны худалдан авалтаас хамааран буцаан олголтын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Хувь хүний орлогын албан татварын 2016 оны тайлангаар 74170 иргэнд 44.5 тэрбум төгрөг буцаан олгохоос 63643 иргэнд 39.3 тэрбум төгрөгийг буцаан олгосон. Буцаан олголт 88.7 хувьтай байна. Татварын буцаан олголт хангалтгүй байгаа нэр бүхий 11 аймгийн татварыг эхний хагас жилд багтаан буцаан олгоход дэмжлэг үзүүлэх талаар ТЕГ-ын даргын 2017.06.15-ны өдрийн 01/1803 дүгээр албан бичгийг Сангийн Яаманд хүргүүлэв.

2.9 Эрсдэлийн удирдлагын талаар.

ТЕГ-ын даргын 2017 оны А/09 дүгээр тушаалаар татварын эрсдэл тооцох шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, өөрчлөх, хүчингүй болгох, татварын албаны үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлийг удирдах, бууруулах, хэрэгжилтийг нь хянах, эрсдэлийн шинжилгээний үр дүнтэй танилцах ажлыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг бүхий ТЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хороог 8 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна

ТЕГ-ын даргын 2017 оны А/46 дугаар тушаалаар "Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам", "Эрсдэлийн удирдлагын хорооны хурлын дэг"-ийг, А/47 тушаалаар "Хяналт шалгалтын үр дүнд эрсдэлийн шинжилгээ хийх заавар"-ыг, А/65 дугаар тушаалаар Татварын албаны 2017 оны эрсдэлд суурилсан татвар төлөгчийн сегмент бүрээр ангилсан татварын хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэв. Мөн дүүргийн татварын хэлтсээс зарим татвар төлөгчдийг НТГ-г шилжүүлсэнтэй холбогдуулан ТЕГ-ын даргын 2017 оны А/109 дугаар тушаалаар Нийслэл, дүүргийн татварын албадын 2017 оны "Татварын хяналт шалгалтад хамруулах эрсдэл бүхий татвар төлөгчийн жагсаалтыг батлан хэрэгжүүлээ.

Татвар төлөгчийн эрсдэл тооцох дэд үзүүлэлтийн матрицыг сегмент бүрээр боловсруулж, ТБМНС-д бүртгэлтэй татвар төлөгчдийн 2016 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Татварын ерөнхий газрын харьяа нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийг судлан 387 татвар төлөгчийн холбогдох өөрчлөлтийг эрсдэлийн тооцооллын програмд оруулав. Мөн харилцан хамааралтай нэр бүхий 32 татвар төлөгчдийг эрсдэлийн үнэлгээг хийж, хяналт шалгалтын төлөвлөгөөнд орууллаа.

"Татварын албаны үйл ажиллагааны дотоод эрсдэл тооцох заавар"-ыг боловсруулаад байна.

Хөндлөнгийн мэдээллийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хөндлөнгийн мэдээлэл солилцох хүрээг өргөтгөж, ҮХОБанк, ХАС банк, УБ хотын банк, Үндэсний хөгжлийн газар, Хил хамгаалах ерөнхий газар, ЦЕГ, Зам тээвэр хөгжлийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба, ОӨУБЕГ-тай мэдээлэл харилцан солилцох гэрээ, санамж бичиг байгуулав.

Мэдээлэл харилцан солилцох гэрээний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирсэн тусгай зөвшөөрлийн 1'485 мэдээ, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас ирсэн 4'133 мэдээ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас ирсэн тусгай зөвшөөрлийн 541 мэдээ, Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн 5'275 мэдээ, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирсэн тусгай зөвшөөрлийн 331 мэдээ, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас ирсэн тусгай зөвшөөрлийн 145 мэдээ, Сангийн яамнаас 2016 оны Е-балансын мэдээлэл, төрийн сангийн зарлагын гүйлгээний дэлгэрэнгүй мэдээ, Төмөр замын удирдах газраас ирсэн 81'890 ширхэг мэдээлэл, Эрчим хүчний яамнаас ирүүлсэн 703 иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл, Спирт бал бурам" ХХК-с ирүүлсэн 18 аж ахуйн нэгжид хамаарал бүхий спирт борлуулсан мэдээ, "Тайгам алтай" ХХК-ийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтын мэдээлэл, "Оюу толгой" ХХК-аас авсан 198 иргэнтэй хамаарал бүхий түрээсийн төлбөрийн мэдээлэл, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн 2016 оны сонгуульд нэр дэвшигч 375 иргэн, хандив өгсөн 11'528 иргэний мэдээлэл, цахим төлбөрийн баримтын системийн мэдээллээр 20.0 саяас дээш үнийн дүн бүхий "Аж ахуйн нэгж илгээгээгүй" төлөвт байгаа татвар төлөгчдийн мэдээллийг хөндлөнгийн мэдээллийн санд тус тус хөрвүүлсэн байна. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай мэдээлэл солилцох 01/004, 52 дугаар гэрээг 2017 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр байгуулж, 4000 ААН-ийн мэдээллийг авч, татварын тайлантай тулгалт хийж хөндлөнгийн мэдээллийн санд бүртгэлээ.

Гааль, татвар, санхүү МТТөвУТҮГ-аас ирүүлсэн өндөр үнийн дүн бүхий худалдан авалт хийсэн 1'512 иргэний мэдээлэлд эрсдэл тооцон 1'368 иргэний худалдан авалтад төлсөн НӨАТ-ын 20 хувийг баталгаажуулж, 144 иргэний худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг эрсдэлтэй гэсэн үндэслэлээр баталгаажуулаагүй болно. Худалдан авалтад төлсөн НӨАТ-аа буцаан авах 82 өргөдлийн мэдээлэлд үндэслэн эрсдэл тооцож, 48 иргэний НӨАТ-ыг буцаан олгуулахаар шийдвэрлэж, 34 иргэний өргөдөлд НӨАТ-ын тухай хууль, журмыг зөрчснөөс НӨАТ-ыг буцаан олгох боломжгүй гэсэн хариуг албан бичгээр хүргүүлээ.

Түүнчлэн цахим төлбөрийн баримтын системд 2016 онд 100 мянгаас 20 сая төгрөгийн борлуулалтын мэдээгээ илгээгээгүй 1'293 татвар төлөгчдийн 23'852 ширхэг сугалааны дугаарт хамаарах 11,4 тэрбум төгрөгийн мэдээлэл, 2017 оны 1 дүгээр улиралд 877 татвар төлөгчдийн 6'138 ширхэг сугалааны дугаарт хамаарах 55,9 тэрбум төгрөгийн мэдээллийг гарган, татвар төлөгчөөр тайлагнуулах арга хэмжээг авч байна.

Импортоор бараа оруулсан иргэдийн мэдээлэлд эрсдэлийн шинжилгээ хийж 23,3 тэрбум төгрөгийн мэдээлэл бүхий 1940 иргэнтэй ХХОАТТухай хуулийн дагуу татварын тооцоо хийж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрсдэлийг ялгаатай тогтоох хүрээ", "Эрсдэлийн мэдээллийн сангийн ашиглалт, баяжуулалт" сэдэвт сургалт", Япон улсын Олон улсын их сургуулийн дэд профессор ЮсүкеЖинай "Статистикийн учир шалтгаан ба түүний энгийн амьдрал дээрх гаргалгаа" сэдэвт сургалт, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, профессор Б.Мөнхзаяатай хамтран "Дотоод эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлох арга зүй" сэдэвт сургалтыг ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон УТОХГ, НТГ, дүүргүүдийн татварын албадын холбогдох албан хаагчдыг хамруулав.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай програм хангамжийг хөгжүүлэх ажлын хүрээнд Фишер системийн эрсдэлийн тооцооллын хэсэг, эрсдэлийн тайлангууд хэсгүүдэд өөрчлөлт оруулах, хөндлөнгийн мэдээллийн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, нэмэлт өөрчлөлт оруулахаар бодлогын даалгаврыг боловсруулж, програмын хөгжүүлэлтийг хийж байна.

2.10 Татварын хяналт шалгалтын талаар

Татварын маргаантай акт, дүгнэлт, тэдгээрийн шийдвэрлэлтийн байдлын судалгааг хийж, дүгнэлтийг хэрхэн шийдвэрлэх талаар татварын албадыг тухай бүр чиглэл, арга зүйгээр ханган ажиллалаа.

Эхний улирлын байдлаар хяналт шалгалтын мэдээгээр 551 татвар төлөгчийг хяналт шалгалтанд хамруулж, 423 акт, 107 илтгэх хуудас, 25 НӨАТ-ын илүү төлөлтийг баталгаажуулах акт үйлдэж, нийт 551 шийдвэр гаргаж, 276,258,803.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 23,587,31.9 мянган төгрөгийн төлбөр төлүүлэхээр шийдвэрлэснээс 265,977.5 мянган төгрөгийн өрийг барагдуулсан нь өрийн барагдуулалт 1.13 хувьтай мэдээтэй байна.

Татварын албаны хэмжээнд оны эхэнд 338 татвар төлөгчтэй холбоотой 319.3 тэрбум төгрөгийн маргаантай акт, дүгнэлт байсан бол тайлант хугацаанд 12 татвар төлөгчийн хүсэлтээр 1.6 тэрбум төгрөгийн төлбөр нэмэгдсэн байна. Өмнөх оны актаас 16 татвар төлөгчийн 1.5 тэрбум төгрөгийн төлбөр бүхий маргаантай акт эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Шийдвэрлэгдээгүй 483 дүгнэлт байна. Үүнээс хуулийн байгууллагад шалгагдаж байгаа 259, татварын албанд прокурорын тогтоол гарсан боловч шийдвэрлэгдээгүй 198 дүгнэлт байна. Тайлант хугацаанд Прокурорын байгууллага 224 дүгнэлтийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснээс татварын алба 3 илтгэх хуудас, 23 актыг үйлджээ.

Татварын албанд аж ахуй эрхлэгчээр бүртгүүлээгүй, орлого олсон боловч татварын албанд тайлагнаагүй 243 иргэнийг хяналт шалгалтанд хамруулах ажлыг зохион байгуулж байна. Хяналт шалгалтын 4 дүгээр сарын 5-ны мэдээгээр 71 татвар төлөгч иргэнийг татварын хяналт шалгалтад хамруулан 56 акт, 15 илтгэх хуудас үйлдэн 5,4 тэрбум төгрөгийн зөрчилд 155,1 сая төгрөгийн төлбөр ногдуулж, 67 иргэний хаяг байршлийг тодруулах арга хэмжээг авав.

ТЕГ-ын даргын баталсан 2017/04 тоот удирдамжийн дагуу харилцан хамаарал бүхий 33 аж ахуйн нэгжид татварын хяналт шалгалтыг хийж байна.

УТОХГ, Орхон, Дархан, Сэлэнгэ, Булган аймгийн татварын хэлтсийн хяналт шалгалтын үйл ажиллагааг шалган, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, цаашид хэрхэн ажиллах талаарх албан бичгээр чиглэл хүргүүлсэн болно.

ТЕГ-ын даргын 2017.01.31-ний өдрийн А/27 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулан онцгой албан татварын тэмдэг шалгах иж бүрдэл бүхий 195 багажийг хүлээн авав. Багажийг татварын албадад хуваарилан хүргүүлсэн болно. Багажийг хэрхэн ашиглах талаар Үндэсний үнэт цаас ХХК-ийн холбогдох мэргэжилтэнтэй хамтарч ТЕГ, Нийслэл, дүүргийн холбогдох байцаагчид сургалт зохион байгууллаа.

ТЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу УТОХГ болон дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй согтууруулах ундаа үйлдвэрлэгч 12 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар үйлдвэрийн технологийн шугам, сав, савлагаанд хийх лац, битүүмж шаардлага хангаагүй, спирт болон архины үйлдвэрт тавьсан ОХУ-д үйлдвэрлэсэн АЛКО-1, АЛКО-2 тоолуур нь ашиглалтын шаардлага хангахгүй, хяналт тавих боломж муу, харуул хамгаалалт өндөр, гэнэтийн шалгалт хийх боломжгүй, хариуцсан татварын улсын байцаагчийн ажлын байр тогтворгүй зэрэг зөрчил илэрсэнг арилгах талаар шаардлага хүргүүлэв. Сангийн яамны 2017.05.03-ны өдрийн 4-г/2537 албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хуучин загварын онцгой албан татварын тэмдгийг шинэ загварын тэмдгээр солих ажлыг зохион байгуулах талаар татварын алба болон онцгой албан татвар төлөгч аж ахуйн нэгжид албан бичиг хүргүүлэн хэрэгжүүлж байна.

2.11 Татварын маргаан шийдвэрлэлтийн талаар

Сангийн сайдын 2017 оны 31 дүгээр тушаалаар Татварын ерөнхий газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөл шинэчлэн байгуулж, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны Б/31 дүгээр тушаалаар нарийн бичгийн дарга, магадлагчийг томиллоо.

Тус газрын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд нийт 31 гомдлыг хүлээн авч, 1 гомдлыг буцаасан. Маргаан таслах зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулан 42 гомдлыг хэлэлцэж, 2 гомдлын хугацааг Захиргааны ерөнхий хуулийн 94.2-д зааснаар нь сэргээхээр шийдвэрлэв.

Хуралдааны шийдвэрийг цаг тухайд нь тогтоолын хэлбэрт оруулан албажуулж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор татварын албаны цахим мэдээллийн санд байршууллаа.

Тайлант хугацаанд 18 хэрэг маргаанд шүүхэд төлөөлж оролцлоо. Үүнд Захиргааны 16 хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсоноос 3 хэрэг маргаан эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Иргэний нэхэмжлэлтэй 2 хэрэг маргаанд хариу тайлбарыг гаргасан. Шүүх хуралдаан товлогдоогүй 15 хэрэг маргаан шүүхийн шатанд хянагдаж байна.

Гурав. Стратегийн зорилт 2.4.3. *“Татвар төлөх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлж, татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээг хэвшүүлэх, татварын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх, татварын хууль тогтоомж, үйл ажиллагааны талаар олон нийтийн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх” хүрээнд;*

3.1 Татварын үйлчилгээний талаар.

Тайлант хугацаанд татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх 1800-1288 тусгай дугаарын 700-тайшугаманд 56'623 минутын 30'739 хандалтад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариулт өгсөн болно. Автомат хариулагчид татвар төлөгчдийн үлдээсэн 5 асуулт, цахим шуудангаар ирүүлсэн 21 асуултад цахим хэлбэрээр хариулыг өгч, биечлэн ирсэн 29 татвар төлөгчдөд хуулийн дагуу зөвлөгөө өгөв. Татвар төлөгчдийн утсаар асуусан асуултын 29.5 хувь нь НӨАТУС-ийн талаар, 24.2 хувь цахим тайлангийн систем, тодорхойлолт, тоон гарын үсгийн талаар, 15.2 хувь нь ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар, 7.3 хувь нь татварын албадын хаяг, утас, байршил, татвар төлөх дансны талаар, 4.1 хувь нь ХХОАТ хуулийн талаар, 2.9 хувь нь ААНОАТ-ын тухай хуулийн талаар, 14.5 хувь нь ТЕХ, давхар татварын гэрээ болон бусад татварын хууль, тогтоомж талаарх асуулт байв. Дээрх шугаманд хандсан 20 гомдлын 70 хувь нь ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал хүлээн

авахтай холбоотой, 30 хувь нь татварын албадын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гомдол байна. Гомдлыг тухай бүр холбогдох газар, хэлтэст хүргүүлж шийдвэрлэв.

НӨАТ-ийн чиглэлээр 1800-1288 тусгай дугаарын 500-тай шугамаар 05 сарын 31-ны байдлаар 128'682 иргэд хандсанаас, 42'522 нь байцаагчтай холбогдож, 350 иргэн биечлэн ирж зөвлөгөө авлаа. Зөвлөгөө авсан иргэдийн 30.6 хувь нь цахим төлбөрийн баримтад бүртгүүлэх талаар, 19.0 хувь нь НӨАТ-ын урамшуулал буюу буцаалт олголтын талаар, 19.9 хувь нь нууц код нэвтрэх үгээ мартсан, хуулийн этгээд төлбөрийн баримттай холбоотой нэхэмжлэл үүсгэх талаар, 9.1 хувь нь 131313 дугаартай холбоотой асуудлаар, 7.0 хувь нь цахим тайлангийн системийн талаар, 10.1 хувь нь хонжворын мөнгө дансанд ороогүй, сугалаатай холбоотой асуудлаар, 1.2 хувь төлбөрийн баримт өгөхгүй байгаа талаар, 2.1 хувь нь бусад чиглэлээр ханджээ. Төлбөрийн баримт олгохгүй байгаа асуудлаар ТҮТ-д 1533, Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд 11-11 дугаар утсаар 149, нийт 1682 гомдол ирсэн байна. Гомдлын 1175 буюу 69.9 хувийг шийдвэрлэж, 507 буюу 30.1 хувийг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Тайлант хугацаанд Татварын үйлчилгээний төвөөс бага өртэй 12'817 татвар төлөгчийн 2975.8 сая төгрөгийн татварын ногдол, өрийн барагдуулахаар дуудлага хийхээс 5 дугаар сарын байдлаар 10'817 татвар төлөгчийн 2,770.8 сая төгрөгийн татварын ногдол, өрийг барагдуулах дуудлага хийв.

Дуудлагын дараа татвар төлөгчийн 8%-ийг буюу 1007 татвар төлөгчийн 347.2 сая төгрөгийн ногдол, өрийг татварын албадад буцаав. Үүнд 54,8 сая төгрөг өрийг төлөх амлалт өгөөгүй 158 татвар төлөгч, 48.8 сая төгрөг өрийн мэдээлэл буруу 148 татвар төлөгч, татварын ногдол, өрийн босго давсан 27.6 сая төгрөгийн өр бүхий 66 татвар төлөгч, байрших хугацаа дуусгавар болсон 216.1 сая төгрөгийн ногдол, өр бүхий 635 татвар төлөгч, утасны мэдээлэл буруу болохыг тогтоосон 212.6 сая төгрөгийн ногдол, өр бүхий 871 татвар төлөгчийн мэдээллийг харьяалах татварын албадад буцаасан байна.

Татвар төлөгчид үйлчлэх ажлын хүрээнд ирээдүйн татвар төлөгчдөд сургалт явуулах хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хүрээнд Монголын оюун ухааны музейтэй танилцан оньсон болон хөлөгт тоглоом хийх, татварын нэг өдөр макет, уран зургийн зохиомж хийх талаар судалж байна. Мөн татвар төлөгчдөд зориулсан үзүүлэнгийн танхимыг байгуулан танилцуулга, татвар төлөгчдөд тараах гарын авлагын жагсаалт, гарын авлага хэвлүүлэх төсвийн төслийг боловсруулаад байна.

“Иргэн та бизнес эрхэлдэг бол ...” ХХОАТ-ын гарын авлага, “ebarimt.mn-ийн цэсүүдийг тайлбар”, “Татвар төлөгчийн бүртгэл”-тэй холбоотой 3 төрлийн гарын 25,0-28,0 мянган ширхэг хэвлүүлэн татвар төлөгчдөд хүргэсэн болно.

Түүнчлэн харьяа татварын албадын нэг цэгийн лавлах утас, татвар төлөхтэй холбоотой асуудлаар татвар төлөгч холбогдох лавлах утсаа тогтмол ажиллуулан үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх талаар чиглэл хүргүүлж, утасны жагсаалтыг сайтад байршууллаа. Татвар төлөгчийн бүртгэлийн журам болон ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлттэй холбоотой маягт гарын авлага, заавар, НӨАТ-ын буцаан олголттой холбоотой татвар төлөгчдөд зориулсан мэдээлэл сурталчилгаа, сэтгэл ханамжийн судалгааны санал асуулга, цахим төлбөрийн системд бүртгүүлэхгүй байгаа шалтгааныг тодруулах асуулт, англи, монгол хэлээр бэлтгэсэн гадаад улс орны татварын хувь хэмжээний талаарх мэдээлэл, груп компаниудад зориулсан “Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил, үйлчилгээ, барааны гүйлгээний тайлангийн маягт” зэргийг татварын албаны цахим хуудаст байршуулав.

3.2 Татвар төлөгчдийн сургалтын талаар

Татвар төлөгчдийн татварын боловсролыг дээшлүүлэх, улмаар татвар үнэн зөв хугацаанд тайлагнаж, төлөхөд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор дараах сургалтыг хийлээ. Үүнд:

- “ААНОАТ-ын хуульд орсон нэмэлт, өөрчлөлт, цахим тайлангийн талаар” сургалтыг 3 удаа зохион байгуулж, нийт 562 татвар төлөгч оролцсон байна.
- “Үнэ шилжилт”-ийн тайлангийн шинээр батлагдсан маягтын талаар **Олон улсын татварын зөвлөх PwC компанитай хамтран зохион байгуулсан сургалт** 150 орчим татвар төлөгчдийг хамрууллаа.
- АТҮТ-өөс ирсэн албан бичгийн дагуу 01 дүгээр сарын 21-ны өдөр АТБӨЯХАТ-ын хуулиар авто бүртгэлийн 45 ажилтанд 1 цагийн сургалт хийсэн болно.
- PwC /ПрайсуотерхаусКуперс/ ХХК-тай хамтран “Хил дамнасан гэрээ хэлэлцээр, түүний татварын асуудлууд” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, 110 аж ахуйн нэгжийн 160 ажилтан хамрагдав.

- “Гарааны компаниудын Татварын хууль эрхзүйн орчин” сэдэвт сургалтыг БСШУСЯ-ны Инноваци, өндөр технологийн хэлтэстэй зохион байгуулж, 32 компанийн удирдлага хамрагдлаа.
- ТEG-ын Татвар төлөгчдийн танхимд “Татварын хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар танилцуулга, татварын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт нийт 200 орчим татвар төлөгч оролцов.
- Хуульчдын холбоотой хамтран “Өмгөөллийн үйл ажиллагаанд татвар ногдуулах нь” сэдэвт хэлэлцүүлэг сургалт явуулж ХХОАТ, НӨАТ-ын татвар ногдуулах, тайлагнах талаар 2 байцаагч илтгэл тавив.

3.3 Татварын албаны үйл ажиллагаа, татварын хууль, тогтоомжийг сурталчлах талаар

ААНОАТ-хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт, ХХОАТТХ-ийн хөнгөлөлт чөлөөлөлт, АТБӨЯХАТТХ-ийн хэрэгжилт, татвар хураах явц, НӨАТ-ын 20 хувийн буцаан олголт НӨАТ-ын цахим төлбөрийн баримт, НӨАТ-ын чөлөөлөгдөх бараа, ажил үйлчилгээ, урамшууллын талаар Блүүмберг, ММ агентлаг, NTV, СтарТВ, Ийгл, ETV, VTV, SBN, ТВ9, 25-р суваг телевиз, ETV, NBS, C1, MNC телевиз, Эх орон, МонголHD телевизээр 91 удаа ярилцлага, мэдээ тодруулгыг явуулж, ikonnews.mn, itoim.mn, gogo.mn, oloo.mn, eagle.mn news.mn mass.mn цахим хуудас, Монголын Үнэн сонин, Ардчилал, Засгийн мэдээ сонин, Зууны мэдээ зэрэг сонин, сайтад 36 удаа мэдээ, тодруулга ярилцлагыг нийтлэн Татварын албаны цахим хуудаст 60 гаруй баннер, мэдээ мэдээллийг байршуулав. Youtube хаягт шинээр 18 видео байршуулснаар 40192 хэрэглэгч, нийт 83834 минут үзжээ.

Татварын албаны цахим хуудсанд 90 мэдээ, фото мэдээ, видео, фэйсбүүкт 235 мэдээ, мэдээлэл баннер, шторк, нэвтрүүлэг байршуулснаар 29 мянган хэрэглэгчид шууд хүрч, давхардсан тоогоор 2,5 сая хэрэглэгчид, твиттерт 172 мэдээ, мэдээллийг байршуулснаар 7.7 мянган хэрэглэгчид шууд хүрч, давхардсан тоогоор 730,1 мянган хэрэглэгчдэд хүрсэн байна.

Эдийн засгийн сэтгүүлчдийн “Өөрчлөлт” клубээс зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож 25 хэвлэл мэдээллийн байгууллагад НӨАТ болон татварын шинэчлэлийн асуудлаар тодруулга ярилцлага өгөв.

Удирдах ажилтны зөвлөгөөний хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулан, NTV, UBS, Eagle телевизээр төлбөртэй мэдээ, МҮОНТ-ийн ММ агентлаг, VTV8 ЭхоронТВ-ээр зөвлөгөөнд оролцогчдын ярилцлагыг нэвтрүүлэв.

МҮОНРТ-ын хамтран ажиллаж 14 хоног тутам Үндэсний радиогийн 2 шууд нэвтрүүлэгт оролцон татвар төлөгчдийн асуултад хариулж байна.

Сангийн яамтай хамтран НӨАТ-ын 20 хувийн буцаан олголт болон татварын цаг үеийн асуудлаар хэвлэлийн бага хурал зохион байгуулав. Хэвлэлийн бага хуралд 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллага оролцлоо.

Сангийн яамны “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг зохион байгуулахтай холбогдуулан ТEG-ын даргын үүрэг гүйцэтгэгчийн 2017 оны А/108 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулав. “Татвар төлөгч танд зөвлөө” татварын албадын үйлчилгээ, ХХОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хууль /ebarimt.mn/-ийн сургалт хийх, АТБӨЯХАТ, АБТ, АЗАТ Татварын алба харгалзахгүй хураах банкны үйлчилгээ, явуулын “Авто оношлогоо”-ны үйлчилгээ, стандартын шаардлага хангасан кассын машин, POS төхөөрөмж нийлүүлэгч компаниудын үзэсгэлэн худалдаа, татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагуудын үзэсгэлэн худалдаа, татварын сэдэвт оюутан сурагчдын гар зураг, зохион бичлэг, үндэсний тоглоом наадгай болон шилдэг бүтээлийн үзэсгэлэн, e-баримт сугалааны азтан болсон иргэдэд “Батламж” гардуулах ажиллагаа, НЗДТГ-тай хамтран Нийслэлийн шилдэг татвар төлөгчдөд шагнал гардуулах “Ёслол хүндэтгэлийн ажиллагаа” зэрэг арга хэмжээг зохион байгуулан амжилттай оролцлоо.

Gosmart компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан Татварын албаны цахим хуудас шинээр ашиглалтад оруулсан юм. Шинэ цахим хуудсанд аймаг нийслэл дүүргийн татварын хэлтсүүдийн фэйсбүүк хаягийг холбов. Тус хуудаст Авлигын эсрэг хууль болон Авлигатай тэмцэх хөтөлбөр, Санхүүгийн ил тод байдалтай холбоотой мэдээллүүд, НӨАТ-ын суутган төлөгчийн бүртгэлийн мэдээ, ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах 3-р ээлжийн иргэдийн нэрсийн жагсаалтыг байршууллаа.

Татварын албаны үйл ажиллагаа болон бусад цаг үеийн шаардлагатай 59 үйл явдлын 8260 орчим кадр зураг авч архивлан, файлаар хадгалав.

3.4 Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах талаар

ТEG-ын даргын 2017 оны А/71 дүгээр тушаалаар татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан, төлөвлөгөөний... ажлыг амжилттай зохион байгуулав. Тухайлбал:

- “Татварын хуулийг хэн сайн мэдэх вэ?-2017” тэмцээнийг их дээд сургуулийн оюутаны дунд зохион байгуулах, Ерөнхий боловсролын бага ангид “Татварын тухай ойлголт”, дунд ангид “Аз жаргалтай амьдрахад татварын үүрэг”, ахлах ангид “Хариуцлагатай татвар төлөгч”, их дээд сургуулийн оюутнуудад “Татварт –иргэний оролцоо” сэдвээр хичээл орох, “Би-Ирээдүйн татвар төлөгч” сэдэвт дунд, ахлах ангид зориулсан видео хичээлийг улс орон даяар явуулах;
- Шилдэг 43 татвар төлөгчийг шалгаруулан, цом батламж гардуулах, биет тоглоом 32, зохион бичлэг 117, гар зураг 121 бүтээл ирснийг шалгаруулж, шагнаж урамшуулах;
- Хэрэглэгчийн систем нийлүүлэгч компаниудын Кассын машин, POS төхөөрөмжийн хямдралтай (лизинг) худалдааг худалдаа зохион байгуулахтай холбогдох мэдээллийг татвар төлөгчдөд хүргэх зэрэг ажлыг зохион байгуулжээ.

Татвар төлөгчдийн өдрүүдийг зохион байгуулснаар татвар төлөгчдийн татварын мэдлэг боловсрол, татвар төлөх нийгмийн сэтгэхүйг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн. Энэ жилийн татвар төлөгчдийн өдрийн онцлог ажлын нэг нь ирээдүйн татвар төлөгчдөд орон даяар сургалт явуулж, татварын боловсролыг гэр бүлд хүргэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулсанд оршино.

Татвар төлөгчдийн өдрүүдийг сайн зохион байгуулсан татварын албадыг шалгаруулан, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Багануур Сүхбаатар дүүргийн татварын хэлтэс, Нийслэлийн татварын газар, Улсын төсвийн орлого хяналтын газрыг шагнаж урамшуулав.

Татвар төлөгчдийн өдрүүдээр Татварын албаны 60 секунд, 14 секундын 2 шторк бэлтгэн, UBSTV төлбөртэй мэдээ 6 удаа, шторк 23 удаа, 1 нэвтрүүлэгт зочин оруулж, МҮОНТ-ээр ММ мэдээнд зочин оруулж, шторк 6 удаа, NTV телевизээр Оюутан сурагчдын цуврал 4 дугаар нэвтрүүлэг шторк 30 удаа, Влоомверг ТВ-ийн гадна дэлгэцээр 6 удаа, Төв шуудангийн гадна дэлгэцээр 2 шторк 1200 удаа, Төв номын сан, Баруун 4 замын урсдаг 2 самбараар Татвар төлөгчдийн өдрүүд, Эх орны хөгжлийн бүтээгч эрхэм татвар төлөгч танд баярлалаа. текстийг 1000 гаруй удаа явуулав. Түүнчлэн зохиолч, найруулагч Д.Төрбатын "Танихгүй сэтгэл" уран сайхны киног үндэсний төв архиваас авч "Монгол кино" төсөлд хамруулан, ТВ9, UBSTV, МҮОНТ, NTV телевизүүдээр нэвтрүүлэв.

Дөрөв. Стратегийн зорилт 2.4.4. “Татварын албаны хэмжээнд хүний нөөцийн бодлогыг шинэчлэн тодорхойлох, бүх шатны сургалт зохион байгуулах, ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, санхүү, хөрөнгө оруулалтын зохистой бодлогыг хэрэгжүүлэх эрх хэмжээний хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;” хүрээнд;

4.1 Удирдлага, зохион байгуулалтын талаар

Тайлант хугацаанд ТЕГ-ын даргын зөвлөлийн хуралдааныг 5 удаа зохион байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөө, журам, дүрэм, заавар, ажлын тайлан, шалгалтын дүн зэрэг нийт 16 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Татварын ерөнхий газрын шуурхай хуралдааныг 12 удаа зохион байгуулж, 75 үүрэг даалгавар өгснөөс хэрэгжсэн 66 хэрэгжиж эхэлсэн 9 үүрэг даалгавар байна. Захиргааны зөвлөлийн 1 удаа зохион байгуулж, 1 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

Цаг үеийн шуурхай асуудлаар ТЕГ-ын зохион байгуулалтын нэгжүүдээс харьяа албадтай тухай бүр цахим хурлыг зохион байгуулж, заавар чиглэл, үүрэг даалгавар өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан болно.

Татварын албаны 2017 оны Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2017 оны 2 дугаар сарын 8-наас 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав. Зөвлөгөөнд татварын албаны 35 нэгжийн дарга нар оролцсон. Зөвлөгөөнд оролцогчдод Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи, МУИС-иас удирдах албан тушаалтан багш, мэргэжилтэнг урьж сургалт зохион байгуулж, ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн 11 нэгжийн дарга чиг үүргийн дагуу арга зүйн зөвлөмж, үүрэг даалгавар өгөв. Мөн ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа нэгжийн 2017 оны хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр шалгарсан татварын албадыг Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулав.

ТЕГ-ын харьяа Мэдээлэл, статистикийн хэлтсийг Сангийн сайдын 2017 оны 18 дугаар тушаалаар Мэдээлэл, технологи статистикийн төв болгон өргөтгөлөө. Энэ өөрчлөлттэй холбогдуулан тус төвийн албан хаагчдын 10 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлав.

Татварын ерөнхий газрын 7 давхрын хурлын зааланд давхардсан тоогоор 108 удаа, 8 давхрын зааланд давхардсан тоогоор 63 удаа хурал семинар, зөвлөгөө зохион байгуулагджээ.

4.2 Дээд газрын тогтоол шийдвэр хэрэгжилтийн талаар

2016 оны жилийн эцсийн байдлаар дээд газрын 19 тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг гаргаж, 2017 оны 03/10 дугаар албан бичгээр Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлэв.

Тайлангийн хугацаанд Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол 2, Засгийн газар тогтоол 4, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 1, Ерөнхий сайдын захирамж 2, Сангийн сайдын тушаал 2, албан даалгавар 1, нийт 12 шийдвэр нэмж ирсэнг бүртгэл хяналтад авч, хэрэгжүүлэх ажлыг зохион байгууллаа. Үүнээс хэрэгжсэн 4, хэрэгжиж байгаа 7, хэрэгжилт удааширсан 1 шийдвэр байна. Дорноговь аймгийн Сайншанд сум болон Дэлгэрэх сумыг холбосон хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг улсын төсөвт хүндрэл учруулахгүй байх хэлбэрээр зохицуулан шийдвэрлэх арга хэмжээ авах тухай Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 113 дугаар тогтоолыг хэрэгжилт удаашралтай байна. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд талаар чиглэл авахаар Сангийн Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт албан бичиг хүргүүлсэн боловч хариу ирээгүй байна.

4.3 Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний талаар

Сангийн сайдын 2015 оны 57 дугаарын тушаалд заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 18 мэдээ тайланг Сангийн яамны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт албан бичгээр болон цахимаар хүргүүлэв. Үүнд:

- Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Татварын ерөнхий газраас 2016 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт 2 хуудас
- Засгийн газрын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2012-2016 оны төлөвлөгөөний хүрээнд Татварын ерөнхий газраас 2012-2016 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 6 хуудас
- Татварын ерөнхий газарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт 4 хуудас
- Татварын ерөнхий газрын 2016 оны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн биелэлт 7 хуудас
- Үндэсний татварын албаны 2014-2016 оны хөгжлийн зорилтод хөтөлбөрийн биелэлт 12 хуудас
- Үндэсний татварын албаны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт 8 хуудас
- Үндэсний татварын албанд эрүүл ажлын байр бий болгох хөтөлбөрийн биелэлт 3 хуудас

Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд Сангийн яамны дараах тайлан, мэдээг гаргаж хүргүүлээ. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2017 оны эхний хагас жилийн биелэлт - 2 хуудас
- ТЕГ-ын ил тод байдлыг хангах шалгуур үзүүлэлтийн биелэлт-2 хуудас
- Татварын ерөнхий газарт 2017 оны эхний хагас жилд ирсэн дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт-12 хуудас
- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны эхний хагас жилийн үр дүнгийн гэрээний биелэлт болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Хэрэглэгчийн үнэлгээний тайлан

Сангийн яаманд Татварын ерөнхий газрын 2016, 2017 оны 1, 2 дугаар улирлын байдлаар иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлын мэдээ, танилцуулгын хамт гаргаж цахимаар хүргүүлэв.

Сангийн яамнаас ТЕГ-ын 2016 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 89,3 оноогоор “В” буюу “сайн” гэж үнэлэгдсэн тайланг 5 дугаар сарын 16-нд ирүүлсэн байна. Тус тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г төлөвлөгөөг батлан, хэрэгжүүлж байна.

Татварын албадын дарга нарын 2016 оны үр дүнгийн гэрээг дүгнэлээ. Татварын 22 албадын дарга нарын 6 нь “А”, 14 нь “В”, 2 нь “С” үнэлгээтэй дүгнэв. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарын 2016 оны үр дүнгийн гэрээг 9 нь “А”, нь 2 нь “В” үнэлгээтэй дүгнэлээ. Үр дүнгийн гэрээг дүгнэх үеэр дотоод бүтцийн болон харьяа нэгжийн дарга нарт чиг үүргийнх нь дагуу холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

Татварын ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг, Сангийн сайдтай ТЕГ-ын даргын 2017 оны үр дүнгийн гэрээний хамт батлуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дээрх үр дүнгийн гэрээ, төлөвлөгөөний дагуу Төсвийн шууд захирагчтай Татварын ерөнхий газрын дэд дарга болон зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа нэгжийн дарга, Нийслэлийн татварын газар, аймгийн татварын хэлтсийн дарга нартай 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

4.4 Хүний нөөцийн талаар

Тайлант хугацаанд ТЕГ-ын даргын нийт 298 тушаал гаргаснаас А тушаал 121, Бтушаал 177 тус тус батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Хүний нөөцийн чиглэлээр

- Албан тушаалд томилох -30
- Сэлгэх, шилжүүлэн томилох-17
- Албан тушаалаар чөлөөлөх -48
- ТЕГ-ын мэдэлд шилжүүлэх-5
- Чөлөө олгох- 45 /хүүхэд асрах-12, цалинтай-19, цалингүй-14/
- Ажил хавсран гүйцэтгүүлэх-1
- Түр чөлөөлж, нөөцөд бүртгэх-5
- Цалин тогтоох, нэмэгдэл олгох 2, нийт 153 тушаалыг баталлаа.

Татварын албаны хэмжээнд хүний нөөцтэй холбогдолтой албан хаагчдын дэлгэрэнгүй судалгаа, цалингийн судалгаа, орон тооны судалгаа, нөөцөд бүртгэлтэй албан хаагчдын судалгаа, татварын мэргэшсэн нягтлан бодогчийн судалгаа, мэргэшсэн нягтлан бодогчийн судалгаа, тэтгэвэрт гарах албан хаагчдын судалгаа, 16 хүртэл насны хүүхэдтэй албан хаагчийн судалгааг зэрэг 7 төрлийн судалгаа хийсэн болно.

Татварын ерөнхий газар, Сургалтын төв, Дуудлагын төвийн албан хаагчдын хувийн хэргийг бүрдүүлэх, баяжилт хийх ажлыг тухай бүр хийж байна.

ТЕГ-ын даргын 2017 оны Б/69 дүгээр тушаалаар “ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж болон харьяа нэгжийн 153 албан хаагчид, харьяа татварын албаны нэгжийн дарга нарын 2017 оны ээлжин амралтыг хуваарийг батлан хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Татварын ерөнхий газрын ажлын үнэмлэхийг 152, татварын улсын ахлах байцаагчийн үнэмлэх, тэмдгийг 10, татварын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийг 12, хураагчийн тэмдгийг 85 тэмдэг албан хаагчид олгожээ. Мөн Засгийн газрын ордонд нэвтрэх үнэмлэхийг дотоод бүтцийн нэгжийн 8 даргад гаргуулах хүсэлт хүргүүлж үнэмлэхийг хүлээлгэн өгөв. Албан паспорт шинээр авах 4 албан хаагч, сунгалт хийлгэх 2 албан хаагчийн холбогдох бичиг баримт материалыг бүрдүүлж Гадаад хэргийн яамны консулын газарт хүргүүлж шийдвэрлүүлэв.

Дотоод албан томилолтын хуудас 22-ыг олголоо.

Эхний хагас жилд ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр төлөвлөгөөний хүрээнд 23 хүнд тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжид 437.9 сая төгрөг, давхардсан тоогоор 12 татварын албад 5.9 сая төгрөгийн шагнал, 18 ажилтанд 47.0 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж тус тус олгосон байна.

4.5 Шагнал, урамшууллын талаар.

Тайлант хугацаанд Төрийн дээд одон медаль, Засгийн газрын салбарын болон Татварын ерөнхий газрын шагналд нэр дэвшсэн 7 албан хаагчийн шагналыг хүлээн авч ТЕГ-ын 2016 оны тайлангийн хуралд гардуулах ажлыг зохион байгууллаа. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор-1
- ✓ Алтангадас одонгоор-3
- ✓ Хөдөлмөрийн хүндэт медиалаар-3

Ардын хувьсгалын 96 жилийн ойн баярыг тохиолдуулан Татварын албадаас 186 албан хаагчийн шагналын материалыг хүлээн авч, холбогдох яам агентлагт уламжлав. Үүнд:

- ✓ Сүхбаатарын одонд-1
- ✓ Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонд-5
- ✓ Алтангадас одонд-28
- ✓ Хөдөлмөрийн хүндэт медиалд-43
- ✓ Санхүү эдийн засгийн хүндэт тэмдэгт-8
- ✓ Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэгт-48
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан цол тэмдэгт-3
- ✓ Эдийн засгийн хүндэт тэмдэгт-1
- ✓ Сангийн яамны жуух бичигт-47
- ✓ Хууль зүйн яамны Жуух бичгээр-2

Ардын хувьсгалын 96 жилийн ойн баяр, татварын албаны 25 жилийн ойг тохиолдуулан Татварын ерөнхий газрын шагналд татварын албадаас 158 албан хаагчийн шагналын материал ирснээс шагналын болзол, журмын шаардлагыг хангасан 138 албан хаагчийг шагнаж урамшууллаа. Үүнд:

- ✓ Татварын ерөнхий газрын Хүндэт тэмдэгт-37
- ✓ Жуух бичигт-51
- ✓ Баярын бичигт-50

Мандах бүртгэл дээд сургуулийн 25 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийн 2 багшийг Татварын ерөнхий газрын хүндэт тэмдгээр шагнав.

4.6 Төрийн албаны салбар зөвлөлийн ажлын талаар

Татварын албаны удирдах албан тушаалд томилогдсон албан хаагч, төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд томилогдсон албан хаагчийн товч судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Татварын ерөнхий газрын төрийн албан хаагчийн мэдээллийг бүрэлдэхүүн хөдөлгөөний цахим тайланг програмд нэг бүрчлэн оруулж, 2017 оны 1 дүгээр сарын 10-ны Төрийн албаны зөвлөлд **цахим хэлбэрээр хүргүүлэв.**

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тогтоолоор гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан хэрэгжүүлсэн болно.

Төрийн албаны зөвлөлийн Татварын ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2017 оны төлөвлөгөөг баталж салбар зөвлөлийн тогтоол гаргав. Мөн Төрийн албаны зөвлөлийн Татварын ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох хавсралтуудын хамт хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Нийт албаны хэмжээнд зэрэг дэв ахиулах болон шинээр олгуулах албан хаагчдын судалгааг гаргаж, холбогдох журмын шаардлагыг хангасан 181 албан хаагчид зэрэг дэв олгох, 98 албан хаагчийн зэрэг дэв ахиулав.

Татварын ерөнхий газар болон харьяа нэгжийн 12 удирдах албан тушаалд Төрийн албаны тухай хууль, тогтоомжийн сонгон шалгаруулалтыг хийж, үүрэгт ажилд нь томиллоо. Мөн Төрийн албаны зөвлөлд албан хүсэлт хүргүүлэн Нийслэлийн татварын газар, 9 дүүргийн Татварын хэлтсийн даргын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг нээлттэй зохион байгуулав.

4.7 Авлига, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар

Татварын албадыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах зөвлөмж хүргүүлэх, "Баталгааны маяг"-ыг авахтай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах чиглэлээр албан бичгээр 2 удаа, цахим шуудангаар 5 удаа мэдээлэл хүргэж, майл болон утсаар холбогдон зөвлөмж арга зүйгээр хангав. Татварын албаны хэмжээнд 1393 албан хаагчийн ХАСХОМ-ийн баталгааны маягыг хуулийн хугацаанд баталгаажууллаа. Баталгааны маягыг гаргаагүй, хоцроосон албан хаагч байхгүй болно. Татварын албаны ХАСХОМ-н тайлангийн нэгтгэлийг 2017 оны 02 дугаар сарын 24-ний 03/613 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газар хүргүүлэв.

Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн албан хүсэлтийн авлигаас урьдчилан сэргийлэх, ХАСХОМ-ын чиглэлээр сургалт зохион байгуулж, нийслэлийн хэмжээний татварын албадын холбогдох удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулав. Сургалтаар өгсөн заавар чиглэл, материалийн орон нутгийн татварын албадад хүргүүлэв.

Татварын албаны удирдах албан тушаал, улсын байцаагчийг сэлгэн ажиллуулах, сонгогдохоор нэр дэвшсэн 82 албан хаагчийн мэдүүлгийг хуулийн дагуу хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн 82 албан хаагчдад дүгнэлт гаргуулсан болно. Шинээр томилогдсон 66 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн аван цахим мэдээллийн санд оруулж баталгаажууллаа.

Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн дагуу Татварын ерөнхий газрын авлигын эсрэг үйл ажиллагааны 2017 оны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Авлигатай тэмцэх газраас шалган зааварчлах ажлын хэсэг 2017.04.02-07-ны өдрүүдэд Татварын ерөнхий газарт ажиллаа. Ажлын хэсэгт шаардлагатай судалгаа, холбогдох материал болон тайлбарыг гаргаж өгөв.

Тайлант хугацаанд албан хаагчтай холбогдох асуудлаар татвар төлөгчөөс ирсэн 6 гомдол, байгууллагын удирдлагын шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулах санал бүхий 19 албан бичиг судлан шийдвэрлэв. ТЕГ-ын даргын 10 тушаалаар ёс зүйн зөрчил гаргасан 15 ажилтанд сануулах, 31 ажилтанд цалингийн хэмжээг бууруулах, 4 ажилтныг ажлаас халах сахилгын шийтгэл хүлээлгэсэн болно. Одоогийн байдлаар сахилгын шийтгэл ногдуулах шаардлагагүй гэж үзсэн 4, гомдлоо буцааж татсан 1 иргэн, албан бичгийг шийдвэрлэхээс өмнө өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн 1, харьяалах татварын хэлтэст шилжүүлсэн 5, ТЕГ-ын даргаар шийдвэрлүүлэхээр хүлээгдэж байгаа 4 дүгнэлт байна.

Нийт ирүүлсэн гомдол, дүгнэлтийг зөрчлийн шинжээр ангилбал:

- Үнэт цаас, тооцоот маягтаар хураасан орлогыг хугацаа хоцроож тушаасан, дутуу тушаасан, засварласан, тооцоо хийгээгүй зэрэг-6
- Ажлын цаг ашиглалттай холбоотой. Хоцорсон, тасалсан г.м -5

- Татварын ажилтны нэр хүнд, харилцааны соёлтой холбоотой-2
- Татварын орлогын төлөвлөгөө тасалсан-3
- Ажлын цагаар архи уусан-3
- Хяналт шалгалтын ажилтай холбоотой-2
- Бусад /Гэр бүлийн, ажилдаа хайнга хандсан, даргатай муудалцсан гэх /-4байна.\

Ёс зүйн зөрчлийг шийдвэрлэхтэй холбогдуулан Ёс хорооны ажиллах журмыг шинэчлэн боловсруулаад байна.

4.8 Албан хаагчдыг сургалтад хамруулан, мэргэшил, мэдлэг чадварыг дээшлүүлэх талаар

Татварын албаны ажилтан, албан хаагчдын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх чиглэлээр “Татварын албаны ажилтан, албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийг ТЕГ-ын даргын 2017 оны А/11 дүгээр тушаалаар батлан мөрдөж байна.

Татварын улсын байцаагчийн мэргэшүүлэх сургалтыг Хөвсгөл, Дундговь, Дорноговь, Сүхбаатар, Төв, Дорнод, Өмнөговь, Хэнтий, Говьсүмбэр аймгийн татварын хэлтсийн татварын улсын /ахлах/ 238 байцаагчдад мэргэшүүлэх сургалтыг цахим хэлбэрээр 30 хоног, танхимын сургалтад 3 өдөр зохион байгууллаа.

Татвар хураагчид зориулсан чиглүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, 10 татварын албаны 118 хураагч хамрагдсан байна. Цахим сургалтын системд нэвтрэх хэрэглэгчийн эрхийг 54 хураагчид нэмж олгосоноор 235 хураагчийг чиглүүлэх сургалтад цахим хэлбэрээр хамруулав. Үүнээс мэдлэг бататгах тестийн шалгалтыг 220 хураагч өгсөн бөгөөд шалгалтын дундаж оноо 68,4 байв.

Олон улсын татварын чиглэлээр Казахстан улсын РwС компанийн захирал АнуарМукановын “Үнэ шилжүүлэлтийн олон улсын ойлголт, зарчим, үнэ шилжилтийн аргууд”; менежер МаринаТарнавскагийн “Олон улсын татварын ойлголт, зарчим, Давхар татварын гэрээний онол ба хэрэглээ, татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх дүрмийг мөрдүүлэх”, РwС компанийн Монгол дахь захирал Ч.Цэндмаагийн “Монгол Улсын үнэ шилжилтийн дүрэм журам, хэрхэн мөрдүүлэх” зэрэг сэдвээр сургалтад нийслэлийн хэмжээний татварын албадын 103 албан хаагч хамрагдсан байна.

Удирдах ажилтныг хөгжүүлэх сургалтын зохион байгуулж, Нийслэлийн хэмжээний татварын албадын 100 гаруй албан хаагчийг хамруулав. Сургалтад Татварын мэргэшсэн зөвлөх О.Цогт “Монгол улсын татварын тогтолцоо, цаашдын чиг хандлага”, Ч.Цэндмаа “Татвар төлөгчдийн үйлчилгээ, татварын зөвлөх үйлчилгээ”, Ц.Энхжавхлан “Татварын ажилтныг хөгжүүлэх олон улсын чиг хандлага”, Д.Энхсайхан “Татварын бааз суурийг нэмэгдүүлэх, зарим арга зам”, Ц.Цэцэгмаа “Удирдах ажилтны манлайлал”, “Багийн хөгжил ба амжилт” сэдэвт хичээл зааж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзоригийг урьж “Захиргааны ерөнхий хууль болон Татварын эрх зүйн харилцаа” чиглэлээр илтгэл хэлэлцүүлэв.

ХХОАТ-ын тайлан, хөнгөлөлт, чөлөөлөлтийн материал хүлээн авах чиглэлээр 2 удаагийн сургалтыг явуулж, нийслэл, дүүргийн татварын албадын 257 татварын улсын байцаагч оролцов. Татвар төлөгчдөд дээрх чиглэлээр сургалт хийх 50 албан хаагчийг сургалтад хамруулсан болно. “Харилцаа –Татварын албаны үйлчилгээ”, “Төрийн болон Татварын албаны ёс зүй сэдэвт сургалтад УТОХГ, Нийслэл, дүүргийн Татварын хэлтсийн 589 албан хаагчийг оролцуулсан байна.

Татварын албаны нийт албан хаагчдад “Бичил, жижиг, дунд болон том хэмжээний бизнес эрхлэгчдийн татварын удирдлагыг боловсронгуй болгох нь” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулав.

Санхүү татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг тайлагнаж буй өнөөгийн байдал, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй асуудлаар татвар төлөгчид, татварын улсын ахлах байцаагчдыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Татварын албаны ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн англи хэлийг хэрэглэх арга зүйн мэдлэгийг үе шаттайгаар олгох сургалтыг 3 улирлаас эхлэн зохион байгуулахтай холбогдуулан англи хэлний ерөнхий мэдлэгийн хичээлийг 5,6 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгууллаа. Энэ хүрээнд англи хэлний 23 цуврал хичээл, аудио ном, уран зохиолын ном, сонсгол сайжруулах дуунууд, “НӨАТ-ын луйвар”, “Олон улсын татвараас зайлсхийх, татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэхийг эсэргүүцэх” сэдэвт сургалтын материалыг цахим сургалтын системд байршуулсан болно.

Олон улсын нягтлан бодох бүртгэлийн сургалтад багш нарыг мэргэшүүлэх чиглэлээр “СТОУС-ын 2016 оны өөрчлөлтүүд” сэдэвт хичээлд 8 багш, “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт” сэдэвт хичээлд 3 багш, “Барилгын гэрээний орлого ба зардлын нягтлан бодох бүртгэлийн стандарт” сэдэвт хичээлд 3 багш, “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт” сэдэвт хичээлд 2 багшийг хамруулсан байна.

Сургалтын төвийн татварын улсын (ахлах) байцаагчдыг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн нийгмийн ухааны салбараас зохион байгуулсан "насанд хүргэгчдэд сургалт явуулах арга барил, заах арга зүйг хөгжүүлэх, багшлах эрх авах" 21 хоногийн сургалтад хамруулж, МУИС-ийн захирлын 2017 оны А/36 дугаар тушаалаар "Багшлах эрхийн үнэмлэх" олгосон байна.

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/ болон Монголын татварын албатай хамтран хэрэгжүүлж буй "Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь" сэдэвт 2 дугаар шатны төслийн сургалтад хамрагдахаар хүсэлтээ ирүүлсэн 88 албан хаагчаас түвшин тогтоох шалгалтыг авав.

KOICA Scholarship Program-ийн хүрээнд зарлагдаж буй 2017 оны магистрын тэтгэлэгт сургалтад хамрагдах албан бичгийг ТЕГ, Нийслэл, дүүргийн татварын албадад хүргүүлэн, 2 албан хаагч материалаа ирүүлсэн Сангийн яаманд уламжлав.

Мэдээлэл технологийн дэвшил түүнийг ач холбогдлыг үнэлэх талаар Харилцаа холбооны газраас зохион байгуулж буй нээлттэй чуулганд Татварын ерөнхий газраас 12 албан хаагчийг хамруулав.

Хүний нөөцийн хөгжлийн үндэсний зөвлөлөөс "Хүний нөөцийн удирдах ажилтны үндэсний зөвлөгөөн"-ийг зохион байгуулахтай холбогдуулан "Төрийн албаны хүний нөөцийн бодлого, тулгамдаж буй асуудлууд" сэдэвт салбар хуралдаанд Татварын ерөнхий газраас 3 албан хаагч оролцов.

Монголын хуульчдийн холбооны гишүүн өмгөөлөгчдийн дунд 2017 оны 3 дугаар сарын 21-ний өдөр "Өмгөөллийн үйл ажиллагаанд ногдуулах татвар" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийслэл хотын албан татварын хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2017 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн ТУБ нарт "Шийтгэврийн хуудсаар хариуцлага хүлээлгэхэд анхаарах зүйлс" сэдвээр танилцуулга хийж, чиглэл өгсөн.

Хууль, зүй дотоод хэргийн яамнаас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр зохион байгуулсан Захиргааны ерөнхий хуулийн, мөн энэ оны 6 дугаар сарын 5-9-ний өдрүүдэд зохион байгуулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн сургагч багш бэлтгэх сургалтад холбогдох албан хаагчид хамрагдсан болно.

Олон улсын татварын ахисан шатны мэдлэг олгох "Олон улсын татварын асуудал, Үнэ шилжилтийн асуудал" сэдэвт тав хоногийн сургалтад ТЕГ-ын болон харьяа газар, нийслэл дүүргийн Татварын хэлтсийн хяналт шалгалтын албан хаагчдыг хамруулав.

Тайлант хугацаанд Татварын ерөнхий газрын даргын 14 тушаалаар гадаад оронд хурал зөвлөгөөн, сургалтад 38 албан хаагчийг хамруулаад байна.

Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага "ЖАЙКА"-тай хамтран "Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагааг болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь" төслийн 2-р үе шатны хүрээнд "Өр дуудах төвийн чадавхийг бэхжүүлэх" сэдэвт сургалт Япон улсын Токио хотноо 2017.02.22-ноос 2017.03.01-ний хооронд зохион байгуулагдсан сургалтад 15 албан хаагч хамрагдав.

Татварын албаны татварын улсын байцаагчдыг туршлага судлуулах, мэргэжил дээшлүүлэх чиглэлээр Словени Улсад 2017 оны 2 дугаар сарын 21-нээс 23, 6 дугаар сарын 20-ноос 22-ны хооронд зохион байгуулагдсан сургалт, БНХАУ-ын Янжоу хотноо 2017 оны 3 дугаар сарын 6-наас 10-ны хооронд "Орлогын албан татвар" сэдэвт сургалт, БНУУ-д 2017 оны 3 дугаар сарын 27-ноос 31-ний хооронд зохион байгуулсан "Үндэстэн дамнасан татвар төлөгчийн хяналт шалгалт" сэдэвт сургалт, БНСУ-д "Олон улсын татвараас зайлсхийх, татварын суурийг гажуудуулах, ашиг шилжүүлэх" сэдэвт сургалт, БНСУ-д 2017 оны 6 дугаар сарын 12-наас 16-ны хооронд зохион байгуулсан "Том аж ахуйн нэгжийн татварын удирдлагын орчин үеийн хөгжил" сэдэвт сургалтад, БНУУ-д зохион байгуулагдсан сургалтад тус тус 2 албан хаагчийг хамруулжээ.

ТЕГ-ын даргын 2017.03.15-ны А/60 тушаалаар Япон улсын Токио хотод 2017.03.22-23-ны өдрүүдэд ОУ-ын Валютын сан, Япон улсын Сангийн яамны хамтран зохион байгуулж буй Азийн орнуудын Татварын дээд түвшиний 8 дахь удаагийн хуралд ТЕГ-ын ТОГ-ын дарга Д.Цогтжаргалыг оролцуулав.

Татварын ерөнхий газрын мэдээллийн цагийг зохион байгуулж Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсээс газар хөдөлтийн гамшгийн үед авах арга хэмжээний талаар, АТГ-аас Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн танилцуулга, Юнител ХХК-иас үйлчилгээ, бүтээгдэхүүний танилцуулга, сурталчилгаа зэрэг 13 мэдээ, мэдээллийг хийжээ.

4.9 Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Тайлангийн хугацаанд байгууллагаас явсан 1758 албан бичгийн бүрдлийг шалган дугаар өгч, шуудангаар 1129 албан бичгийг холбогдох газруудад хаяглан явуулав.

Татварын ерөнхий газарт 2520 албан бичиг, тогтоол, шийдвэр факс ирснээс хариугүй 1351, хариутай 1169, үүнээс хариу явуулсан 1097 албан бичиг, 72 албан бичиг хугацаа болоогүй. Нийт 347 өргөдөл хүсэлт ирснээс хариу явуулсан 311 өргөдөл, хугацаа болоогүй 36 өргөдөл байна. Нийт 9 гомдол ирснээс хариу явуулсан 6 гомдлын хариуг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй судлагдаж байгаа 3 гомдол байна.

Тайлангийн хугацаанд хэвлэмэл хуудсын зарцуулалтад хяналт тавьж, А5 хэвлэмэл хуудас 3284 ширхэг, А4 хэвлэмэл хуудас 3587 ширхэг, тушаалын хэвлэмэл хуудас 618 ширхэг, гадаад хэвлэмэл хуудас 102 ширхэг, албан даалгаврын хэвлэмэл хуудас 8 ширхгийг тус тус зарцуулжээ.

Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс 2016 оны 301 хадгаламжийн нэгж хүлээн авч, 1127 хадгаламжийн нэгжийг ашиглуулан, 486 хуудсанд "хуулбар үнэн" тэмдэглэл хийв. Архивын 2015-2016 оны 739 боть баримтад лавлах үйлдэв.

4.10 Нийтийг хамарсан арга хэмжээний талаар

Сар шинийн баярыг тохиолдуулан 2017.02.24-ний өдөр тус газрын 49 ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, Олон улсын эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан 2017.03.07-ны өдөр Татварын ерөнхий газрын эмэгтэйчүүдэд баяр хүргэх арга хэмжээг зохион байгуулав.

ТЕГ-ын албан хаагчдын дунд "Эрүүл агаар эм" сэдэвт явган аяллыг 2017.04.15-ны өдөр Төв аймгийн Манзуширын хийд-Богдхан уулын ноён оргил "Цэцээ гүн" чиглэлээр зохион байгуулав.

Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн албан хаагчдын дунд сагс, гар бөмбөгийн тэмцээнийг 2014 оны 4 дүгээр сарын 22-23-ны өдөр зохион байгууллаа.

Сангийн яамны хүрээнд 2017 оны спортын арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар сонгогдон, бэлтгэл ажлыг холбогдох байгууллагатай хамтран хийсэн боловч, уг арга хэмжээ Сангийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу хойшлогдсон болно.

Төв аймгийн Зуунмод сумын иргэн Г.Сара охины эмчилгээний зардалд хандив цуглуулах ажлыг ТЕГ-т зохион байгуулж, 636,0 мянган төгрөгийн хандивыг цуглуулан холбогдох дансанд шилжүүлэв.

Татварын хэлтсийн ТУБС.Болорчимэгийн гадаадад эмчлүүлэхэд шаардлагатай эмчилгээний зардал хүссэн Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн албан хүсэлтийн дагуу, хандивын уриалгыг татварын албадад хүргүүлж, хандивт цуглуулсан мөнгийг холбогдох шилжүүлжээ..

4.11 Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтын талаар

Оны эхнээс 33 татварын албанд Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн төсвийн хязгаарт багтаан урсгал төсвийг төсвийн зүйл тус бүрээр сараар хуваарилан баталж, сар бүр эрхийг нь нээн өгч зарцуулалтад нь хяналт тавив. Төсвийн шууд захирагч нараас ирүүлсэн төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг хүлээн авч үндэслэл, тооцооллыг хянан, эхний хагас жилд 33 татварын албаны төсвийн хуваарьт 345.5 сая төгрөгийн өөрчлөлтийг хийлээ.

Татварын албадын 2017 оны үйл ажиллагаанд дутагдаж буй урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийн судалгаа тооцоог гарган Сангийн сайд, Сангийн яамны холбогдох газарт албан бичгээр хүсэлт хүргүүлснээр тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 276.0 сая төгрөгөөр, нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлыг 60.0 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 250.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж хийлгэв. Энэ тодотголын дүнд өр нэмж үүсэхгүй байх, татварын албадын үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдсэн болно.

Татварын албадын 2018 оны төсвийг бодит байдалд тулгуурлан үнэн зөв төлөвлөх, холбогдох судалгаа, тооцоог хянах, төсвийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ТЕГ-ын даргын 2017 оны А/124 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Татварын албаны хэмжээгээр эхний хагас жилд батлагдсан төсөв хуваарийн дагуу 05 дугаар сарын дүнгээр 12.6 тэрбум төгрөгийн эрх нээснээс 11.8 тэрбум төгрөгийг зарцуулан, төсвийн зарцуулалт 93.6 хувь болж 0.8 сая төгрөгийн хэмнэлт гаргасан болно.

Тайлант хугацаандаа 120.0 сая төгрөгийн өглөгөөс 91.3 сая төгрөгийг барагдуулж, өглөгийг 76.1 хувиар бууруулав.

ТЕГ-ын нийт 155 ажилтанд эхний хагас жилд 719.8 сая төгрөгийн цалин тооцон олгож, нийгмийн даатгалд ажил олгогч болон даатгуулагчаас нийт 167.1 сая төгрөг, ХХОАТ-т 66.6 сая төгрөгийг тус тус төлж тайлан мэдээг хуулийн хугацаанд нь гарган хүргүүлэв. Цалингийн санд багтаан 2, 3 дугаар сарын үр дүнгийн урамшууллыг тооцон олгох арга хэмжээг авлаа. Эхний хагас жилийн дүнгээр цалин хөлс, ЭМНДШ, ХХОАТ-ын өр, авлагагүй ажилласан болно. Ажилчдын цалингийн картыг ажилтан бүрт цахимаар хүргүүлж ажиллаж байна.

Татварын албадын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн нэгтгэж Үндэсний аудитын газраар аудит

хийлгэв. Тус газраас “Зөрчилгүй” гэж дүгнэсэн болно. Аудитлагдсан тайлан, батлагдсан төсөв, хуваарийг ТЕГ-ийн цахим хуудасны ил тод цэсэнд байршууллаа.

Төсвийн гүйцэтгэл, өр, авлагын сарын мэдээ тайланг 33 албадаас гаргуулан авч хянан, Сангийн яамны холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлж ажиллав.

Татварын албадын 33 нягтлан бодогч нарт “Төсвийн төлөвлөлт, хуваарилалт, санхүүгийн менежментийг боловсронгуй болгох нь” сэдвээр 2017 оны 2-р сарын 20-21-ний өдөр сургалт хийж, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Интерактив Би Ай компани, Үндэсний аудитын газраас мэргэжилтэн урьж хичээл заалгав.

Бүртгэл санхүү, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад анхаарч татварын албадад зааварчилгаа хүргүүлж ажиллав. Урсгал болон хөрөнгө оруулалтын төсвөөр худалдан авалт хийх бүрдээ Шилэн дансны тухай хуулийг баримтлан ил тод байдлыг ханган, зарлагын 1,359.3 сая төгрөгийн дүн бүхий 32, 2,628.6 сая төгрөгийн дүн бүхий 25, нийт 3987.9 сая төгрөгийн дүн бүхий 57 гүйлгээг байршууллаа. Түүнчлэн ТЕГ-ын байрны 1-р давхарт цахим дэлгэц, 4-р давхарт мэдээллийн самбар байрлуулж, мэдээ тайлан, мэдээ, мэдээллийг тухай бүр байршууллаа.

Мөн удирдамжийн дагуу Баянгол дүүргийн Татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааг шалган зааварчлав.

Татварын ерөнхий газрын болон нийт албадын хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулахад анхаарч өдөр тутам мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан ба эд хариуцагч, жолооч нарын тооцоог тухай бүр нь гаргуулан авч хянан нягтлан бодох бүртгэл хөтлөн тайланд тусгаж өр авлага, дутагдал гаргаагүй болно.

2017 оны 06-р сарын 20-ны өдрийн дүнгээр 1,303.6 сая төгрөгийн үнэт цаас, 17.1 сая төгрөгийн тооцоот маягт хэвлүүлэх захиалгыг татвар төлөгч, татварын албадаас ирүүлснийг хүлээн авч захиалан хэвлүүлж хүргүүлэх ажлыг хийлээ. Тайлант хугацаанд олгосон үнэт цаас тооцоот маягтын үнэ 1,344.7 сая төгрөг байгаа ба маягт, үнэт цаасны үнэ 1,845.8 сая төгрөгийг төсвийн дансанд төвлөрүүлж, үнэт цаасны тайланг сар бүр татварын албадаар гаргуулан авч хянаж ажиллав.

Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/125 дугаар тушаалаар хөрөнгийн тооллогын комиссыг томилон ажиллаж байна.

4.12 Үйлчилгээ аж ахуй, хангалт, засвар тохижилтын талаар

Эвдэрсэн гэмтсэн эд хогшилд тухай бүр нь үйлчилгээний ажилчдаар засвар, үйлчилгээ хийлгүүлэн эдэлгээний хугацааг уртасгах ажлыг зохион байгуулж ажиллаа.

Татварын ерөнхий газрын байрны дотор гадна талын цэвэрлэгээ үйлчилгээ, тохижилт, ажилчдын ая тух, ажиллах нөхцөлийг хангахад өдөр тутам хяналт тавин цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж, их цэвэрлэгээг 14 хоног тутам хийж ажиллав.

Байрны гадна талбайн тохижилт анхааран зурагжуулж, машины зогсоолыг журамлан цэгцлэв. Гадна талбайн мод, бут сөөг, зүлэгний арчилгаа цэвэрлэгээг Сүхбаатар дүүргийн ТҮК-аар үнэ төлбөргүйгээр хийлгэж 4.5 сая төгрөгийн төсөвт зардлыг хэмнэв.

УТӨХГ, ТҮТ, СТ, ДАГ-ын албан өрөөний засвар, татвар төлөгчид зориулсан танхимын тохижилтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод бүтцийн нэгжүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сургалт сурталчилгаа, албан томиллолтод шаардлагатай төсөв, ажлын машинаар ханган ажиллав. Татварын ерөнхий газрын нийт ажилтнуудад шаардлагатай бичиг хэргийн материал, принтерийн хор зэрэг хангамжийн материалаар цаг тухай бүрд нь хангав.

ТЕГ-ын албан ажлын 5 автомашины ажлын бэлэн байдлыг тогтмол хангаж, үзлэг оношлогоонд тухай бүр оруулан, шаардлагатай засвар үйлчилгээг хийлгэн даатгал, татварт хамруулан, осол аваар, зөрчил гаргаагүй болно.

Ажилчдын ая тухтай ажиллах нөхцлийг хангах зорилгоор цайны газарт тогооч гэрээгээр ажиллуулж хүйтний улиралд үнэгүй халуун аарц, хямд үнэтэй хоолоор үйлчилэхэд 5.6 сая төгрөгийн үнийн хөнгөлөлт үзүүлэв.

Харуул хамгаалалтын ажилд байнгын хяналт тавин ажилласны дүнд эд хөрөнгө хулгай болон харуул хамгаалалттай холбоотой зөрчил гараагүй болно.

ТЕГ-ын ажилтан, албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч, “ИОГ” болон “Эмэгтэйчүүдийн үрэвсэлт өвчний эмчилгээг, орчин үеийн эмийн хэрэглээ” сэдэвт сургалтад хамруулах, Монос, Монофакомпаниудтай хамтран витаминжуулалтын аяныг зохион байгуулах, амин дэмийн хэрэглээ, хеликобактеровчний талаар мэдээлэл хийлгэх, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулав. Энэ аяны хүрээнд витамин болон гоо сайхны бүтээгдэхүүнийг 5-20%-ийн хөнгөлөлттэй урамшуулалт худалдаа хийгдлээ. Мөн ясны сийрэгжилт-75, сахар-71, арьс оношилгоо-68 албан хаагчид үнэ төлбөргүй хийлгэж, хүчилтөрөгчийн коктейлоор үнэгүй үйлчлэв. Мөн “Happy veritas” лаборатортай хамтарч ажиллан элэгний “В”. “С” вирус илрүүлэх шинжилгээг үнэ төлбөргүй хийлгэж, эрүүл ажилтнуудыг ХӨСҮТ-ийн дархлаа судлалын төвөөс элэгний “В” вирусээс урьдчилан сэргийлэх тарилгад 3 удаа хамрууллаа. Уг эмчилгээнд 76 хүн хамрагдсан байна.

Эхний хагас жилд давхардсан тоогоор 1686 ажилтан, албан хаагчид эмнэлгийн анхан шатны тусламж, эмчилгээ үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд 724 удаа тариа хийх, 86 удаа бариа хийх, 2098 удаа бумба тавих, 144 удаа инцра, 74 удаа электрофорез, 21 удаа искра зэрэг туяа эмчилгээ хийн, 305 удаа массажны ороор үйлчилсэн байна. Татварын албаны ажилтнуудын эмчилгээ үйлчилгээнд зориулан эм, боох материал авахад урсгал төсвөөс 859.3 мянган төгрөг зарцууллаа.

Тав. Стратегийн зорилт 2.4.5. “Татварын хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох, дотоод аудитыг бэхжүүлэх” зорилтын хүрээнд;

5.1 Дотоод бүтцийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, бусад холбогдох тогтоомжтой нийцүүлэн “Татварын байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх заавар”-ыг ТЕГ-ын даргын 2017 оны А/57 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна.

ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлийн хамт емониторинг программд оруулж, сар бүр биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав.

ТЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа нэгжүүдийн 2016 оны үйл ажиллагааны үр дүнд Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан, дүн мэдээг ТЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, ТЕГ-ын даргын 2017 оны А/34 тоот тушаалаар батлав.

Сангийн сайдын “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийх нэгдсэн удирдамжийн дагуу дотоод аудит хийх удирдамжийг батлан ТЕГ-ын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс, Нийслэлийн татварын газар, харьяа татварын нэгжүүдийн шилэн дансны тухай хуулийн 2016 оны хэрэгжилт, үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж, дүнг үндэслэн ТЕГ-ын даргын 2017 оны А/69 тушаал гарган хэрэгжүүлж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Сангийн яаманд 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 08/710 дугаар албан бичгээр хүргүүлэв.

5.2 Харьяа нэгжийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх талаар

Баянгол, Баянзүрх дүүргийн Татварын хэлтсийн 2016 оны Татвар хураалтын түвшингийн үзүүлэлтүүд болон НӨАТ, НХАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод аудит хийв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаар “Их хэмжээний сайжруулалт хэрэгтэй” гэсэн дүгнэлт гарсанд холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлж байна.

Баян-Өлгий, Ховд аймгийн Татварын хэлтэст гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ТЕГ-ын даргын А/121 дүгээр тушаал гарган хэрэгжүүлэв. Гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Баян-Өлгий аймгийн Татварын хэлтэс 74.3 оноогоор “С” үнэлгээтэй, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд 52.5 хувийн биелэлттэйгээр, Ховд аймгийн Татварын хэлтэс 80.1 оноогоор “В” үнэлгээтэй, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд 58.9 хувийн биелэлттэйгээр, Увс аймгийн Татварын хэлтэс 80.3 оноогоор “В” үнэлгээтэй, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийн эрчимжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд 60.5 хувийн биелэлттэйгээр дүгнэгдэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний 2016 оны дүнгээр тэргүүлсэн УТОХГ, Хан-Уул дүүрэг, Сэлэнгэ, Сүхбаатар, Архангай аймгийн татварын хэлтсүүдэд өргөмжлөл гардуулсан болно.

Зургаа. Дүгнэлт

Татварын алба хуулиар хүлээсэн Төсвийн орлого бүрдүүлэх үүргээ биелүүлэн 2017 оны эхний хагас жилд улс, орон нутгийн төсөвт 1645.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1749.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 106.3 хувиар биелүүлсэн, Төсвийн ерөнхийлөн захирагчтай Төсвийн шууд захирагчийн 2017 оны үр дүнгийн гэрээний хавсралт болох Татварын ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 91.7 оноо буюу “А” үнэлгээгээр дүгнэн Сангийн яаманд тайлагнасан зэргийг үндэслэн Татварын ерөнхий газрыг 2017 оны эхний хагас жилд “хангалттай” ажилласан гэж дүгнэж байна.

Долоо. Цаашид анхаарах зарим асуудал

Татварын алба татварын хууль тогтоомжыг хэрэгжүүлэх, хяналт тавих, татвар төлөгчдөд үйлчлэх, улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх үндсэн чиг үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхэд онцгой анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Монгол Улсын Сангийн Сайдын 2017 оны 1 дүгээр албан даалгаврын заалт бүрийг ханган биелүүлж, биелэлтийг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт сар бүрийн эхний 5 хоногт багтаан Сангийн яаманд танилцуулах /ТОГ, ТТХГ, ТХШАЗГ/
- НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах ажлын хүрээнд хууль, тогтоомжийг нийтэд сурталчлан таниулах, бүртгэлийн машины хэрэглээг нэмэгдүүлж жигд ажиллагааг хангах, цахим баримт баталгаажуулалтыг эрчимжүүлэх;
- НӨАТ-ын урамшуулал, буцаан олголттой холбогдох мэдээллийг татварын ногдуулалт, хяналт шалгалтад ашиглах арга зүйг боловсронгуй болгон, бүрэн ашиглах арга хэмжээг авах; /ТТХГ, ТХШАЗГ/
- Бичил, жижиг болон дунд хэмжээний бизнес эрхлэгчийн татварын удирдлагыг боловсронгуй болгох төлөвлөгөөг хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх; /Холбогдох газар, хэлтэс/
- Татварын албаны програм хангамж, мэдээллийн системийг хөгжүүлэн сайжруулж, системийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр үе шаттай ажлуудыг зохион байгуулахад онцгой анхаарах /МТТ/
- Татвар төлөгчийн бүртгэлийг цэгцлэх, татварын бааз суурийг өргөжүүлэх ажлын хүрээнд татвар төлөгчийн тооллогыг хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /ТТХГ/
- Мэргэжлийн мэдлэг ур чадварын түвшин тогтоох арга хэмжээг авч, татварын улсын байцаагчийн эрхийг сунгах, ёс зүйн зөрчлийг судлан цаашид гаргахгүй байх чиглэлээр татварын албадад чиглэл өгөх, холбогдох эрх зүйн актыг боловсронгуй болгох, ажлын хариуцлага алдаж ёс зүйн зөрчил гаргасан албан хаагчид хуулийн дагуу хариуцлага тооцох; /ТЗУГ/
- Менежер нь Төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажиллагааг сайжруулж, улмаар менежерийн буруутай үйл ажиллагааны улмаас байгууллагад учирсан бодит хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах арга хэмжээг авах; /ТЗУГ, СХОХ/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

2017.07.03